

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-32

1. “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох	6-18
2. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	18-21
3. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	21-32

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
05 дугаар сарын 21-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 09 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ж.Батсуурь, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Сүхбаатар, Ж.Эрдэнэбат.

Нэг. “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Эрчим хүчний дэд сайд М.Баярмагнай, Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Соёлын дэд сайд М.Батбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын дарга Э.Батболд, мөн газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, Хот байгуулалтын хэлтсийн шинжээч Э.Ариунням, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Усны газрын дарга З.Батбаяр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, мөн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Энхчимэг, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын Хот байгуулалт, зураг төслийн институтийн эрхлэгч С.Одбаяр, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж, мөн захиргааны Хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны хэлтсийн дарга Г.Дарханчулуун, Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Хосбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

“Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх талаарх мэдээллийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ц.Мөнхцэцэг, Б.Жаргалмаа, Д.Сарангэрэл нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын сайд

Ц.Даваасүрэн, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 15 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслолын албаны дарга Э.Одмөнх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар хариулж, тайлбар хийв.

Хуралдаан Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаан хуралдаж дуусах хүртэл 16 цаг 00 минутаас 17 цаг 04 минутад завсарлав.

Н.Энхболд: Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Баярмаа, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Б.Төрбат, Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны захирагч Д.Эрдэнэбулган, мөн аймгийн Дулаанхаан тосгоны захирагч Ж.Ганболд, Булган аймгийн Хялганат тосгоны захирагч А.Сод-Эрдэнэ, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Нийслэлийн захирагчийн Ажлын албаны төлөвлөлт хариуцсан шинжээч Ц.Батгэрэл, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр, мөн захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд, Удирдлагын академийн Улсын салбарын удирдлагын тэнхимийн багш, доктор Г.Жаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Ц.Баянмөнх, Б.Баярмаа, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан тусгайлсан саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал танилцуулав.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Н.Энхболд: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Э.Бат-Амгалан, Ж.Батжаргал, Б.Баттөмөр, Г.Дамдинням, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Г.Тэмүүлэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Нийслэл Улаанбаатар хот, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын тухайлан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “оршин суугчтай,” гэсний дараа “эсхүл байнгын оршин суугчтай байхаар төлөвлөсөн,” гэж нэмж, 4.3 дахь хэсгийн “эдийн засаг, нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, хэрэгжүүлэх” гэснийг “болон бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, газар зүйн байршил,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дангаараа” гэснийг “нэг” гэж, 5.5 дахь хэсгийн “энэ хуулийн 5.2-г заасныг” гэснийг “тосгоны оноосон нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршил, заагийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.9, 6.1.10, 6.1.11 дэх заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“6.1.9.төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих;

6.1.10.алслагдсан хот, тосгонд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх;

6.1.11.хот, тосгоны зохион байгуулалт, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, хотын зэрэглэл тогтоохтой холбоотой шийдвэр гаргахад их өгөгдлийн тооцоололд суурилах, дэвшилтэт технологийг ашиглах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Хотын” гэснийг “Хот, тосгоны” гэж өөрчилж, 8.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Хотын” гэснийг “Хот, тосгоны гэж өөрчилж, мөн зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж дугаарлалтыг өөрчлөх:

“10.2.Тосгоны удирдлага дараах тогтолцоотой байна:

10.2.1.тосгоны Зөвлөл;
10.2.2.тосгоны Захирагч.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Санал хураалтыг үргэлжлүүлэн явуулахад гишүүдийн ирц хангалтгүй байгаа тул хуралдааныг 18 цаг 12 минутад завсарлуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 59 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 18 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
15 цаг 09 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Бүртгэлдээ орсон гишүүдийг хуралдааны танхимд орж ирэхийг хүсье. Бямбацогт, Доржханд, Мөнхцэцэг ирсэн байж байна. Сарангэрэл гишүүнийг дуудъя. Тогтохсүрэн гишүүнийг дуудъя. Оюунчимэг гишүүн, Жаргалмаа гишүүн, Амарсайхан гишүүн бүртгэлдээ орчихсон байна. Хурлаа эхэлье. Гишүүдийн ирц бүрдсэн байна. Бямбацогт гишүүн, энэ юу маань хаана гарчхав? Ирц маань хаана гарч байгаа билээ энэ шинэ юман дээр чинь. Бямбацогт гишүүн, Доржханд гишүүн, Занданшатар дарга, Мөнхцэцэг гишүүн, Сарангэрэл гишүүн, Тогтохсүрэн гишүүн, энэ шинэ аппаратаа, энэ үү? Сарангэрэл гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Амарсайхан гишүүн, Жаргалмаа гишүүн, Мөнх-Оргил гишүүн, Оюунчимэг гишүүн, Энхболд гишүүн хүрэлцэн ирсэн байна, 11.

ТББХ-ны 24 оны 5 сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг танилцъя. Танилцуулъя. Орхоны хөндийд Шинэ Хархорум хот байгуулах тухай Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх мэдээлэл сонсоно. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд ЗГ-аас 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг хийнэ. Шинэ Зуунмод хотын, Шинэ Зуунмод хотын эрх зүйн, хаана ч яах вэ нэг газар болно, болно, наашаа суучих сайд. Шинэ зуун мод хотын эрх зүйн байдлын тухай

хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд ЗГ-аас 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Ерөнхийлөгчөөс 5 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэхийг ярилцана. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Ганболд нарын 6 гишүүн 5 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх, Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Адьшаа нарын 4 гишүүнээс 2023 оны 6 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. Чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Асуудалдаа орё.

Нэг. “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох

Орхоны хөндийд Шинэ Хархорум хот байгуулах тухай Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар тогтоол гэж байгаа. Энэний хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг сонсьё. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдоод, холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд Барилга, хот байгуулалтын сайд Даваасүрэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Содбаатар даргыг дуудаарай. Сангийн дэд сайд Мөнгөнчимэг, Эрчим хүчний дэд сайд Баярмагнай, Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Халтар, Соёлын дэд сайд Баттөмөр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ТНБД Цогтгэрэл, Боловсрол, шинжлэх ухааны

яамны ТНБД Батжаргал, БХБЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбаяр, цахим хөгжил, харилцаа, Баярбат, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Цагаанхүү, Эдийн засгийн хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр, БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Батболд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Энхманлай, Усны газрын дарга Батбаяр, Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Нацагдорж, мөн захиргааны Хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны хэлтсийн дарга Дарханчулуун, мөн захиргааны Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга Хосбаяр, Барилгын хөгжлийн төвийн Хот байгуулалт, зураг төслийн институтийн эрхлэгч Одбаяр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ихбаяр, БХБЯ-ны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Билэгсайхан, мөн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын Хот байгуулалтын хэлтсийн шинжээч Ариунням, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Энхчимэг нар оролцож байна.

Мэдээллээ сонсъя. Даваасүрэн сайдын микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын ТББХ-ны дарга, эрхэм гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын 1 дүгээр үе шатад хийх ажлын хүрээнд Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршилыг сонгож, техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ хөгжлийн ерөнхий

төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ гэж, Монгол Улсын ЗГ-ын 2020-оос 24 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршилыг судалж, ТЭЗҮ боловсруулна гэж тус тус зорилтуудыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 230 дугаар зарлигаар Орхоны хөндийн түүхэн дурсгалт газарт төр захиргаа, соёл, боловсрол, аялал жуулчлалд түшиглэсэн байгаль орчинд ээлтэй орчин үеийн шийдлийг тусгасан Хархорум хотыг байгуулах холбогдох судалгааг хийх төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг ЗГ-т даалгаж, Юнескогийн дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн Орхоны хөндийн соёлт дурсгалт газрын өв соёлыг хамгаалах, Монголын эзэнт гүрний эртний нийслэл Хархорум хотыг сэргээн байгуулах түүхэн үйл хэрэг, их бүтээн байгуулалтад манлайлан оролцохыг нийт иргэд, аж ахуйн нэгж байгууллагад уриалсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолоор Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтод нийцүүлэн хүн амын нутагшил суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэх, хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, түүх, соёл, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Орхоны хөндийд Шинэ Хархорум хотыг байгуулахаар шийдвэрлэж, Шинэ Хархорум хотыг байгуулахтай холбогдуулан 2023, 2030 он хүртэлх хугацаанд шинэ хот байгуулах газрын байршил, хэмжээг тогтоож, холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зам тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамжийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, хотыг байгуулах ажлыг удирдан зохион байгуулах, байнгын бүтэц, тогтолцоог бий болгох, бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, түүнд шаардагдах хөрөнгийг улс орон нутгийн төсвийн

болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээр төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх, үе шаттай авч хэрэгжүүлэхийг ЗГ-т даалгасан.

Төрөөс баримталж буй бодлого, холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд ЗГ-ын 2023 оны 38 дугаар тогтоолоор Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын үндэсний хороо, 23 оны 40 дүгээр тогтоолоор Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааг тус тус байгуулан ажиллаж, эхний ээлжийн арга хэмжээний төлөвлөгөөг батлан, дараах ажлуудыг хийж гүйцэтгэж эхлээд байна.

Шинэ Хархорум хот байгуулах газрын байриил, хэмжээг тогтоож, ЗГ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор Орхоны хөндийд Шинэ Хархорум хотхон байгуулах зориулалтаар Архангай аймгийн Өгий нуур, Хаашаат сум болон Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэрт нийт 189363,19 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авлаа. Түүнчлэн тус газрын хөрсний судалгаа, инженер, геологийн судалгаа хийгдэх ажил одоогоор хийгдэж байна.

Мөн Хархорум хотын ундны хэрэгцээг хангах усны судалгааны ажлыг эхлүүлэхэд бэлэн болоод байна. Мөн нийслэлээс Шинэ Хархорум хот хүртэлх авто зам, цахилгаан дамжуулах шугам, трасс болон шинэ нисэх буудал, *airport* байгуулах байршилыг сонгон тогтоогоод байна. Монгол Улсын ЗГ-ын нөөц хөрөнгийн санхүүжилттэй Шинэ Хархорум хотын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай инженер геологийн судалгааны ажил 1х2000 масштабтай байр зүйн зураг зохиох болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд заасан хөрөнгө оруулалтаар Шинэ Хархорум хотын усны хэрэгцээний судалгаа, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал концепцыг боловсруулах, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө,

инженерийн дэд бүтцийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах хөрөнгийг баталж, одоо эдгээр ажлууд хэрэгжих, зарим нь тендерийн үе шатдаа ороод худалдан авах үйл ажиллагаа дээр одоо явагдаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаатай хамтран Шинэ Хархорум хотын хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах олон улсын нээлттэй уралдааныг зохион байгуулах ажлын хүрээнд зарлаж, түүнд оролцох мэргэжлийн багуудын бүртгэлийг 24 оны 3 дугаар сарын 18-наас 4 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд зарлаж, нийт 54 улсын 428 баг оролцохоор одоогоор бүртгүүлээд байна. Эдгээр багууд нь 24 оны 7 сарын 16-ны өдрийн дотор өөрсдийн төлөвлөлтийн үзэл баримтлалыг боловсруулж ирүүлэх бөгөөд 8 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл олон улсын нэртэй архитектурч, төлөвлөгч нараас бүрдсэн үнэлгээний багаар үнэлгээ хийлгэн мөн нэгдсэн үзэсгэлэн байгуулж, олон нийтийн саналыг авах зэрэг ажлуудыг зохион байгуулж үр дүнг гаргана. Эдгээр багуудаас 5-ыг сонгож Шинэ Хархорум хотын хөгжлийн концепцыг боловсруулах ажлыг хийнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчид өгсөн чиглэлийн дагуу шинэ Хархорум хотын төв цэг төв талбайн тохижилтын ажил, Ерөнхийлөгчийн ордны цогцолборын зураг төсөл болон Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтыг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлыг Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран хийж байна. Монгол Улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт үндэсний соёл иргэнилийн өв уламжлалыг хадгалсан тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангасан ногоон, ухаалаг, хүн төвтэй шинэ хотыг төлөвлөж байгуулснаар эртний нийслэл Хархорум хотыг дэлхий дахинд шинээр таниулах, соёл, аялал жуулчлалыг хөгжүүлэх, улс

орны нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжих, төвлөрлийг сааруулах, гадаад, дотоод хөрөнгө оруулалтыг татах, шинжлэх ухаан, технологи, инновацад тулгуурласан ажлын байрыг бүс орон нутагт шинээр бий болгох, хүн амын хэт төвлөрлийг бууруулах зэрэг ач холбогдлыг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Шинэ Хархорум хотын одоогийн бүтээн байгуулалтын талаар хийгдэж байгаа ажлын талаар товч танилцуулгад ийм байна. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Н.Энхболд: Даваасүрэн сайдад баярлалаа. Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын явцын талаарх нэмэлт мэдээллийг энэ бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Нацагдорж танилцуулна. Тэнд дэлгэц дээр слайд бэлдсэн байна.

Н.Нацагдорж: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Хархорум хотыг шинээр барих энэ зарлиг шийдвэр гарснаас 23 оны 4 сараас манай байгууллага байгуулагдаад ингээд ажиллаж байгаа. Тэгэхдээ энд бол 23 оны төсөвт бол энэ хотын төлөвлөлтийг хийх, үзэл баримтлал боловсруулах энэ ажлын мөнгө тавигдаагүй байсан. 24 оноос бол энэ мөнгө бол тавигдаж эхэлсэн. Гэхдээ манайх 23 онд зүгээр суухгүй энэ тухайн газрыг Хот байгуулах газрын ТЭЗҮ боловсруулах, сонгох, мөн Газрын тухай хуулиар хот байгуулах газар дээрээ төлөвлөлт хийгээд, төлөвлөлтөө бол тухайн хотын оршин суугчид иргэн, ААН-үүдэд танилцуулсан байх ёстой гэсэн Газрын тухай хуулийн заалт байдаг. Газрыг тусгай хэрэгцээнд авахын тулд. Тийм учраас зайлшгүй энэ төлөвлөлтийн үзэл баримтлал концепцыг хийхээс аргагүй болсон юм.

Тийм учраас өөрсдийнхөө хүчээр үзэл баримтлал, концепцоо боловсруулаад, орон нутгийн иргэдэд танилцуулаад, мөн гадаад, дотоодын

тэр мэргэжлийн байгууллагуудыг урьж ингэж уулзалт, форум зохион байгуулсан. Мөн Улаанбаатар хотод хэд хэдэн удаа мэргэжлийн хүмүүсийн дунд архитекторууд, инженерүүдийн дунд бас танилцуулга хийж ингэж явсан. Энэ ингээд энэ газар маань өөрөө өнгөрсөн энэ оны 1 сард ЗГ-аас тусгай хэрэгцээнд авсан энэ 189 мянган га газрыг Хархорум хот байгуулах тусгай хэрэгцээнд авсан юм. Тэгээд ингээд энэ газар дээрээ одоо бол тэр инженер геологийн судалгаа сая сайд танилцуулчихсан хөрсний судалгаа, усны хайгуул, мөн байр зүйн зураг, мөн археологи палеонтологийн хайгуулын ажил, мөн байгаль орчны үнэлгээний ажлууд бол тендер зарлагдаад хийгээд явагдаж байгаа.

Та бүхэн дээр энэ төлөвлөлтийн концепцыг товч танилцуулахад бол 500 мянган хүнтэй байхаар төлөвлөлтийн тооцоог авч явж байгаа. Энэ газар маань хотын яг суурьшлын бүс маань 25 мянган га-д хийгдэхээр ингээд төлөвлөлтийн концепц хийгдсэн. Энэ 25 мянган га-г бол Улаанбаатар хоттой харьцуулах юм бол 3 дахин том гэсэн үг. Улаанбаатар хотын яг энэ суурьшлын бүс 9200 га байдаг. Тэгэхээр 25 мянган га-д 500 мянган хүнтэй байхаар эхний тооцоо судалгаанууд хийгдээд ингээд явж байгаа юм.

Энэ Хархорум хотын үзэл баримтлал концепц бол 5 хэсгээс бүрдэж байгаа. Мэдээж энэ ямар байгууллагууд байх вэ гэж байгаа. Засаг захиргааны төв байна, эрүүл мэндийн салбар хөгжинө, мөн аялал жуулчлалын салбар хөгжих, өндөр технологийн салбар хөгжих, олон улсын харилцааны салбар хөгжих гэсэн ийм 5 чиглэлээр төлөвлөлтийн концепц хийгдээд явж байгаа. Энэ дээр бол энэ хотын эрэн дээр байршлын зургууд харагдаж байна. Энэ хойноос нь харсан хэсэг. Энэ хотын хөдөлгөөн, хотын өндрийн энэ зүсэлтийн зургууд харагдаж байгаа. Энэ тухайн хотод байх ёстой нийгмийн дэд бүтцийн байгууламж буюу цэцэрлэг, сургууль хэдэн ширхэг байх вэ хаана, хаана байх вэ

гэдэг нь бол үндсэндээ тодорхой болоод явж байгаа юм.

Энэ дээр бол хотын өндөржилтийн зургууд буюу тухайн хотын хамгийн өндөр хэсэг дээр 26 давхар буюу 80 орчим метр хүртэл байна. Мөн дунд хэсэгтээ болохоор газрынхаа зориулалтаас шалтгаалаад 50 метр хүртэл буюу 16 давхар, нийт барилга бол 6 давхраас дээшгүй байхаар ингэсэн ийм тооцооллоор хийгдээд явж байгаа юм. Энэ тухайн газар дээр бол зарим хэсэгт нь бол тариалангийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ААН-үүд байгаа. Өнгөрсөн 7 сар бол ААН-үүдтэй бол энэ төлөвлөлтийг Хархоринд аваачиж уулзалт хийсэн. ААН-үүд бол дэмжсэн. Тийм учраас Архангай аймгийн иргэдийн хурал, Өвөрхангай аймгийн иргэдийн хурал бол хоёулаа бүрэн дэмжсэн тийм шийдвэрээ гаргаад, ингээд ЗГ-т өгч тусгай хэрэгцээнд авсан юм.

Энэ инженерийн дэд бүтцийнх нь үндсэн тооцоонууд байна. Явуулчихъя. Эхний ээлжийн шугам сүлжээ тавих энэ юунууд байгаа. Ингээд ойр орчмынх нь бүс нутгийг одоо юу ямар зориулалтаар төлөвлөх вэ гэдгийг бас давхар хийгдээд явж байгаа. Энд хот байгуулахад үндсэн төв барилгын түүхий эдүүдийн үндсэн тооцоонууд хийгдээд явж байгаа. Энэ дээр бол эхний ээлжийн барилгажилтын төлөвлөлтүүд харагдаж байна. Хотын төв хэсэгтээ төв талбайн ажил хийгдэж эхлэхээр 360 метрийн диаметртэй төв талбай, мөн Ерөнхийлөгчийн ордон, төв цэцэрлэгт хүрээлэн гэсэн энэ барилгын ажлууд бол хийгдэхээр ингэж төлөвлөгдөөд явж байгаа юм. Хотын төв цэгийн бэлгэ тэмдэг энэ дээр харагдаж байна. Явуулчих. Хотын төв цэг дээр бас өндөр 109 метрийн өндөртэй Мөнх тэнгэр гэсэн ийм Чингис хааны онги тамгаар төсөөлсөн ийм цамхаг баригдахаар бас ийм төслүүд хийгдээд явж байгаа.

Цаашидаа ингээд нарийвчилсан төслүүд рүү ороод явчихлаа. Энэ дээр

бол сонирхуулаад. Энэ болохоор төв талбай дээр байх үндсэн хэлбэр загвартай ийм байгууламжууд байгаа юм. Дээр нь энэ 189 мянган га газарт ингэж хотын төлөвлөлтийг хийхээс гадна мөн олон улсын онгоцны буудал, Элсэн тал гэж газарт хотын төвийн төв хэсгээсээ бол 38км-ийн зайтай, мөн Өгий нуурыг дагасан бас аялал жуулчлалын хэсэг гэсэн ийм 3 хэсгээс энэ төлөвлөлтийн энэ шийдлүүд бүрдэж байгаа.

Ингээд бид нар энэ төлөвлөлт хийгээд ингээд концепцоо боловсруулсан ч гэсэн энэ жил бол энэ олон улсын уралдаан зарласан байгаа. Түүрүүн сайд танилцуулсан. Уралдаан зарласан, 1 сарын хугацаанд бүртгэл явагдаж байгаа. Дэлхийн 54 улсын 428 баг бүртгүүлсэн. Эндээс одоо 75 баг нь яг ажлаа хийж байна, яг өөрсдөө хийж байна. Тэгэхээр эндээс төсвөөс мөнгө гараагүй байгаа. 7 сарын 16-нд бол Монголд ирж төслөө танилцуулна. Энэ төслөөс бол 5 төслийг нь бол шалгаруулж авч Үндэсний үндсэн үзэл баримтлалаа боловсруулах юм. Энэ бол дэлхийн хот төлөвлөлтийн жишгээр явж байгаа гэсэн үг. Хамгийн сүүлд бол Солонгос, мөн Филиппин, энэ Берлин, Астана, энэ Египетийн, Филиппин, Египет энэ тэр гэсэн энэ хотууд дандаа л олон улсын уралдаан зарлаж байгаа.

Эндээс сонирхуулахад бол бид нарын сайн мэдэх Казакстан цаг уурын хувьд ойролцоо Казакстан бол олон улсын энэ уралдаан зарласан, 72 мянган га газарт хотоо шинийг барихаар уралдаан зарласан Астанагийн. Энд бол дэлхийн 27 баг орсон. Эндээс Японы баг түрүүлсэн байдаг. Индонез бол 22 онд зарласан 256 мянган га-д 70 баг орж ингээд эхний 5 байрыг нь шалгаруулсан. Энд Хонконг, Сингапур, Индонезын компаниуд шалгарч хамтарч хийсэн байдаг. Өмнөд Солонгосын шинэ нийслэл Сэжун хотод бол 49 баг орсон байдаг, энэ 18-н, одоо ажил нь эхлээд ингээд 400 мянган хүнтэй болчихсон. ЗГ нь оччихсон, одоо парламентын ордноо

барьж байгаа. Герман, Холбооны Герман бол бас Берлин 70 гэдэг 2070 гэдэг уралдаан зарласан, энд бол 40 баг орсон. Одоо ингээд эхний 5 байрыг шалгаруулаад ажлаа хийж байгаа юм.

Тэгээд бид нар яг энэ жишгээр дэлхийн хот төлөвлөгч нарыг энэ Хархорум хотын бүтээн байгуулалтад оролцуулах, дэлхийн хот төлөвлөлтийн чиг хандлага, технологитой яаж хосолж байгаа вэ, уур амьсгалынхаа өөрчлөлт, зохицуулалттай яаж нийцэж байгаа вэ гэдгийг мэдэж авахын тулд өөрсдийнхөө хийсэн энэ материалыг тэр уралдаанд оролцож байгаа багуудад хүргүүлээд, ингээд уралдаанаа зохион байгуулаад явж байгаа.

Энэ одоо газар дээрээ хийгдэж байгаа ажлуудын талаар бол сайд сая танилцуулчихсан учраас давхцаж яриад яах вэ. Зүгээр энд ажлууд бол үндсэн төлөвлөлт хийх суурь ажлууд бол ингээд хийгдээд явж байгаа. Энэ зураг дээр нь харуулаад та бүхэнд бас танилцуулга дээр харуулчихсан байгаа. Инженер геологийн ажил гэхэд л 991 цооног өрөмдсөн байгаа, цагаан сараас хойш өрөмдсөн. Энэ нь бол 6-аас 20 метрийн гүнтэй цооногуудыг өрөмдөж, эндээсээ хөрсний шинжилгээнүүд авч байгаа. Усны хайгуул бол одоо зарлагдаад явж байна. Энэ ажлуудын талаар товч танилцуулчихлаа. Асуултад хариулъя.

Н.Энхболд: Нацагдорж даргад баярлалаа. Танилцуулга мэдээлэлтэй холбогдоод асуух гишүүн байвал нэрээ өгье. Байхгүй юу. Тийм байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Ер нь нэлээд их ажил бас яг төлөвлөлтийн юмнууд, зураг юмнууд хийгдэж байгаа юм байна, тийм байна. Нөгөө олон улсын тендерийн асуудал яригдаад ид явагдаж байгаа юм байна тийм ээ. Ажил нэлээн, тийм байна. Нэмэлт саяынхаа юмнуудыг хэлчих. Даваасүрэн гишүүний, Даваасүрэн сайдын микрофоныг өгөөдөх.

Ц.Даваасүрэн: Ер нь бол бид яг төлөвлөснийхөө дагуу ажил явж байгаа.

Одоо бол бид нар ингээд юу инженер геологийн судалгаа хийгээд түрүүн хэллээ 900 өрөм тавиад ингээд энэ хөрснүүдийг нь судалгаа хийнэ. Энэ хөрсөө түшиглээд бид нар хаана ямар барилга байгууламжууд барих вэ гэдэг юмнуудаа гаргаад ирсний дараа болбол ерөнхий төлөвлөлтүүд, тэгээд хэсэгчилсэн төлөвлөлтүүдийг ингээд хийгээд явна. Одоо болбол бид нар ингээд хөгжлийн ерөнхий концепцоо боловсруулах ажил энэ зун хийгдэнэ. Энэ дээр бол бид нар олон улсын жишигт нийцсэн тэр ухаалаг, ногоон гэдэг юм уу хамгийн сүүлийн үеийн хотын төлөвлөлтийг хийе гэж байгаа юм.

Тийм учраас олон улсын нээлттэй тендерийг бол Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтраад ингээд бид нар зохион байгуулсан. Одоо болбол 54 орны 400 гаруй компани оролцохоор саналаа ирүүлчихсэн, баг оролцохоор саналаа ирүүлчихсэн байгаа юм. Тэгэхээр дэлхий нийслэл учраас болбол үнэхээр бас сонирхдог юм байна. Тийм учраас болбол яг энэ чиг хандлагаас харахад болбол цаашидаа ингээд яг ажил эхлээд явахаар бол хөрөнгө оруулалт ч гэсэн ер нь бас их орж ирэх ийм боломж бол байгаа юм байна гэж ингэж харагдаж байгаа. Тэгээд ажил бол төлөвлөлтийн дагуу явагдаж байгаа гэдгийг бас хэлье. Их Хурлаас гаргасан тогтоолын дагуу бид нар төлөвлөлт гаргаад ингээд хийгээд явж байгаа. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье, орчихсон байсан шүү дээ тийм.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын ажил бол бас боломжийн сайн явагдаж байгаа юм байна. Нэлээд бол инженерийн болон бусад дэд бүтцийн ажлууд хийгдэж байгаа юм байна. Тэгээд үүнтэй холбогдуулаад энэ Шинэ Хархорум хотын яг усны эх үүсвэр, усны нөөцийн асуудал ямар байгаа юм бэ? Ер нь Орхон голынхоо нөөцийг тулгуурлах юм уу? Тэгээд хүн амын тоог бол 500

мянга гэдгээр эхний ээлжид бол төлөвлөж байгаа юм байна тийм ээ? Тэгэхээр цэвэр усны нөөц, тэгээд Орхон голын уснаас усны эх үүсвэрээ татах зэрэг маань байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэрэг нь хэр байх вэ? Энэ чиглэл дээр хаанахын, ямар бодлоготой хамтран судалгаа хийж байгаа вэ гэдгийг асууя.

Н.Энхболд: Даваасүрэн сайд микрофон.

Ц.Даваасүрэн: Одоо ингээд гидрогеологийн судалгаа хийгдэнэ. Тендер зарлагдана ингээд ингээд явж байгаа. Тэгээд энэ үед бол бид нар ингээд бас саяынх шиг ингээд бас гүний усны нөөц нь ямар юм, гадаргын гэдгээ үзчихээд, гүний усны нөөц хүрэлцэхгүй байна гэж үзэх юм бол гадаргын усыг ашиглах, өөрийн чинь хэлээд байгаа тэр Орхон голыг ашиглах энэ бүх судалгаануудыг болбол судалгаа хийгдсэний дараа л хэлж чадна. Энэ хотыг энэ 500 мянган хүнтэй хотыг ашиглах усны нөөц нь гүний усаар байх юм уу, гадаргын усаар байх юм уу гэдэг болбол одоогийн энэ судалгаа хийгдсэний дараа бол тодорхой болно гэдгийг хэлье. Тэгээд манай Нацагдорж бас нэмчихье.

Н.Энхболд: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Н.Нацагдорж: Сайд яг ерөнхий юуг нь хэлчихлээ. Тэгэхдээ яах вэ зүгээр Улаанбаатар хоттой харьцуулахад Улаанбаатар хот бол хоногийн 120 мянган м³ ус хэрэглэдэг юм. Тэгэхээр энэ бол их үрэлгэн ус л даа. Ер нь бол Улаанбаатар хот бол дан гүний усаар хэрэглэж байгаа. Гадаргын ус ерөөсөө ашиглаж чадахгүй байгаа. Мөн ус цэвэршүүлэх байгууламж бол байхгүй байгаа ер нь бол.

Тэгэхээр энэ Хархорум хотын төлөвлөлтөд бол мэдээж бид нар хоногийн хэрэглээг бол 80 мянган м³-ээр тооцож байгаа. Усны хайгуулууд мэдээж 2 талбарт 76 мянган га газар, 48

мянган га газраас 2 талбарт хайгуулын ажил хийгдэнэ. Усны нөөцийн талаар бол нэг их айхтар санаа зовохгүй байгаа. Яагаад гэвэл тэнд 4 голын бэлчир 2 Тамир, 2 Орхон. Ер нь бол усны хайгуулд бол. Гэхдээ бид нар бол их байгаа гэдгээсээ биш гадаргын усыг ашиглах, усыг дахин ашиглах энэ технологи бол энэ хотын төлөвлөлтөд бол зайлшгүй сууна. Одоо бол олон улсын тэр хот төлөвлөгч нар бол ерөөсөө саарал усыг ашиглах, гадаргын ус ашиглах, хур тунадасны усыг ашиглах гэсэн энэ шийдлүүдийг олон янзын санаанууд оруулж ирэх байх гэж бодож байна. Баярлалаа.

Н.Энхболд: Жаргалмаа гишүүн үг хэлье.

Б.Жаргалмаа: Тэгэхээр шинэ хотоо төлөвлөхдөө дэлхийн улс орнууд олон жилийн төлөвлөлттэй, ирээдүйн хөгжлийн гэдэг юм уу тийм ээ хүн амын төвлөрлийнхөө тооцоо судалгааг маш нарийн хийдэг байх гэж бодож байна. Улаанбаатар хот маань анх байгуулагдахдаа нийтдээ 600 мянган хүн амтай гэж төлөвлөгдөж байсан бол өнөөдөр 1 сая 400, 600 мянган хүн ажиллаж, амьдарч байгаа ийм хот. Төвлөрлөө даахааргүй ийм хэмжээнд оччихсон. Өнөөдөр Орхоны хөндий рүү бид нар Ерөнхийлөгчийн ордноо, ЗГ-ын ордноо Номтын хөндий рүү гээд л ингээд л шилжилт хөдөлгөөнийг хийх, төвлөрлийг сааруулах олон арга хэмжээг Монгол Улсын ЗГ-аас авч хэрэгжүүлж байгаа.

Би эндээс юу асуух гээд байна вэ гэвэл үнэхээр 500 мянган хүн амтай хот байна гээд ингээд төлөвлөчихөөр хэдий хугацааны төлөвлөлтийг ер нь 500 мянган хүн гэж тооцож байгаа юм бол? Үнэхээр Ерөнхийлөгч маань Орхоны хөндийдөө суурьшаад, Монгол Улсын бас тодорхой хэмжээний суурьшлын бүс болох энэ ийм төлөвлөлтөөр хийгдэж байгаа энэ хотын хүн амын тооцооллыг ер нь 500 мянгаар тогтоочхож байгаа юм уу? Цаашаа тийм ээ өргөжин тэлэх

ийм боломжгүйгээр зөвхөн 500 мянган хүн амтай хот байна л гэдэг ийм төлөвлөлтийг хийж байгаа юм уу, үгүй юү гэдэг зүйлийг асуух гэсэн юм.

Нөгөө талаар ер нь Монгол Улс газрын доорх ашигт малтмалын судалгаагаар ер нь хэр хийсэн бэ гэдэг зүйлийг би ер нь маш ихээр асуудаг байгаа. Энэ судалгааны ажил хэр их шатад явж байгаа юу? Одоо Баянхонгор аймагт ашигт малтмалын маш олон уурхайнууд, лицензүүд олгогдож эхэлсэн байна гэдэг ийм мэдээлэл байдаг. Ер нь яг энэ тал дээрээ газрын доорх баялгаа бид нар ер нь хэр судалсан юм бэ гэдэг тал дээр бас нэг мэдээллийг өгөөч. Магадгүй хот төлөвлөлтийн ажил хийгдэж байгаа энэ цаг мөчид ашигт малтмалын лицензийн асуудал яригдаад эхлэх юм бол энэ дээр ер нь ямар тийм ээ бодлого баримталж байгаа юм бэ гэдэг зүйлийг асууя.

Нөгөө талаар Улаанбаатар хот маань байгаа Туул, Сэлбэ голынхоо энэ усны нөөцийн асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй, голынхоо голдирлыг өөрчилдөг, гүний усны судалгаа байхгүйгээс шалтгаалан тийм ээ цэвдэг үүсдэг, газрын халиа дошоо үүсдэг, иргэд маань нүүдэллэн шилждэг, хүн ам, хүний амь нас эрсэддэг ийм эрсдэлүүд байдаг. Тэгвэл яг энэ судалгаагаар ер нь хийж, энэ хотын төлөвлөлтөө хийх ёстой юм биш үү тийм ээ? Даваасүрэн сайдын сая хэлж байгаагаар ер нь судалгаа хийсний дараа энэ төлөвлөлт хийгдэх гэдэг, төлөвлөлт одоо хийгдчихсэн байдаг. Гэтэл судалгааны ажил дуусаагүй байдаг. Хэрвээ Ерөнхийлөгчийн том ордноо босгосны дараа тэнд чинь газрын доорх цэвдэг нь үүсээд, халиа дошоо үүсчихвэл яах юм бэ? Тэгэхээр энэ судалгааны ажлын чинь энэ зөрөөтэй байдал байгаад байгаа юм биш үү? Энэ дээр ер нь нэг тайлбар хэлээч гэдэг зүйлийг асууя.

Улаанбаатар хот одоо л Сэлбэ голынхоо усан санг бид нар нөөцөлдөг

байх, нөөцийн сан бүрдүүлдэг, нөөцийн нуур бүрдүүлэх энэ ажил хийгдээд явж байгаа. Тэгэхээр яг энэ чиглэл дээр ер нь ажлын энэ бодлого чинь жоохон зөрөөтэй байгаа юм биш үү, үгүй юү гэдэг дээр тайлбар өгөөч.

Н.Энхболд: Даваасүрэн сайд.

Ц.Даваасүрэн: Жаргалмаа гишүүн чухал асуулт асуулаа. Харин тийм. Бид нар нөгөө одоо энэ инженер геологийн судалгаа хийж байгаа чинь, хөрсний судалгаа хийж байгаа чинь л ерөөсөө тэр. Энэ хөрс нь ямар хөрстэй юм элсэн хөрстэй юм уу, аль эсвэл цэвдэгтэй юм уу үгүй юү гээд энэ бүгдийг чинь одоо тогтоох гэж байгаа байхгүй юу. Энэ гарсны дараа бид нар байрилынхаа төлөвлөлтүүдийг хийнэ. Тийм учраас яг энэ хот төлөвлөлт яаж явдаг вэ яг л тэр дүрэм журмынхаа дагуу явж байгаа. Тэр ундны усны талаар бол би түрүүн хэлчихсэн учраас энэ өмнөх тайлбар бол болчих байх. Тэгээд Нацагдорж тэр нөгөө юуг нь лицензүүд нөгөө бид нар тусгай хэрэгцээнд авсан газартай холбогдолтой мэдээллүүдийг нь нэмээд өгчихье.

Н.Энхболд: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон Нацагдорж.

Н.Нацагдорж: Энэ тэр тусгай хэрэгцээнд авсан газарт бол бид нар анх судалгаа хийгээд орон нутгаас ч юм уу, улсаас юм уу ингээд лиценз олгосон байдлыг нь мэдээллээ өгөөч гэдэг хүсэлтүүд тавьсан. Тухайн үед бол ерөөсөө холбогдох газар мэдээлэл өгөхгүй байсан. Тусгай хэрэгцээнд ЗГ шийдвэр гарсны дараа бол мэдээллээ өгсөн. Хэд хэдэн ашигт малтмал хайгуулын лицензүүд байгаа. Тэр тусмаа төмрийн орд, алтных, мөн элс хайрганых гэсэн. Ихэвчлэн их алтных байдаг юм байна лээ. Мэдээж энэ бол тусгай хэрэгцээнд авсан газрынхаа тэр хууль журмын дагуу цаашидаа цуцлагдах юм уу, байришлалд шилжих юм уу ийм ажлууд явагдах байх.

Газар дээрээ бол үндсэндээ бол яг ийм карьер хайгуул хийгээд явчихсан юм бол байхгүй. Тэр албан ёсны бол лицензүүд бол байдаг юм байна лээ. Мөн бид нар хот орчим тэр ашигт малтмалаа яаж ямар хайрга, дайрга, тэр цемент, тэр бүх юмнуудыг хаанаас олборлох олборлох вэ гэдэг ойр орчмынх нь судалгаануудыг бол давхар хийгдээд явж байгаа.

Түрүүн 500 мянган хүний талаар асуусан. Тэгэхээр хот төлөвлөнө гэдэг маань өөрөө эхлээд бол ямар ч байсан байршилаа сонгох ёстой. Орхоны хөндийн байршлууд дээр бид нар 6 байршил дээр судалгаа хийж байгаад Хархорин орчмынхоо яг энэ бид нарын энэ сонгоод байгаа энэ байршил дээр бол тогтоож 25 мянган га-д хийсэн. Хүмүүс бол ярьдаг юм. Өгий нуур орчимдоо хийхгүй яасан юм, Тоглохын талд хийхгүй яасан юм гэдэг юм, гэх бол бид нар Хархорин сумыг бол орхиж болохгүй. Энэ чинь төлөвлөлтийн хувьд бол Хархорин сумтайгаа ойрхон байх ёстой, түүхэн газартайгаа ойрхон байх ёстой. Тийм учраас сумынхаа ойролцоо 8км-ийн орчимд бол бид нар 25 мянган га-д төлөвлөлтийн үзэл баримтлал боловсруулж байгаа.

Тэр тухайн хот маань ямар хэмжээтэй байх юм, хэдэн хүнтэй байх юм, усных нь асуудал хаанаас байх юм, эрчим хүчний асуудал хаанаас байх юм гэдэг ерөнхий судалгаанууд явж байгаа. Энэ судалгаанууд явсныхаа дараа энэ дээрээ түшиглээд хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдэх юм. Энэ жилдээ багтаад хийгдэнэ гэсэн үг. Энэ дээр болохоор 500 мянган хүнийг асууж байна. Тэгэхээр Улаанбаатар хот бол үндсэндээ бол 500 мянган хүнтэй байна гэж төлөвлөгдсөн. Энэ ямар учиртай вэ гэвэл, яагаад 500 мянга гэж хийсэн юм бэ гэвэл өнөөдөр Улаанбаатар хотод далайн түвшинээс 1310 метрээс доош орших буюу хүн амьдарч болох барилга байгууламж барьж болох газрын талбайн л хэмжээ. Энэ бол 9200 га байдаг юм. Энд л ирээдүйн 20 он гэхэд

Улаанбаатар хот 500 мянган хүнтэй байна л гэсэн үг. Хүн амдаа хуваасан талбайн хэмжээ.

Тэгэхдээ одоо бол 1 сая 700 болчихсон байгаа. Улаанбаатар хотын хүн хүн амьдрах 100 метр, 1 га газар буюу 100-г харьцах нь 100 талбай дээр нормоороо 420 хүн байдаг бол, одоо 2000, 3000 гарчихсан юм зарим байршлууд дээр. Тэгэхээр юманд хэт нягтрал, цаашаагаа Улаанбаатар хотод бүтээн байгуулалт хийгээд л байх юм бол энэ рүү улам бүс нутгийн хүмүүс маань ирээд л, битүү ингээд л нэмэгдээд л байна гэсэн үг. Тийм учраас өрсөлдөх юм уу, Улаанбаатар хотын даацыг авах, Улаанбаатар хотоос хүмүүс шилжих тийм хэмжээний хотыг бол зайлшгүй барих ёстой. Энэ бол дэлхийн жишиг. Ерөөсөө л ингэж л энэ л гарц л байгаа. Өөрөөр шийддэг гарцууд бол байхгүй.

Н.Энхболд: Жаргалмаа гишүүн асуултаа тодруулъя гэж байна. Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Харин тийм. Ерөнхийдөө бид нар 500 мянган хүн гээд тооцчихоор шилжилт хөдөлгөөн суурьшлын тооцооллоо яаж хийх вэ л гэж асуугаад байгаа юм. Яг саяын Улаанбаатар хотын тийм ээ энэ бид нарын алдаа дахиад давтагдах вий. Тэгвэл өнөөдөр 500 мянган хүн Орхоны хөндийд суурьшина гэж тооцчихоор шилжилт хөдөлгөөнөө яах юм бэ, аялал жуулчлалаа яах юм бэ? Бүгд найрамдах Солонгос улсын ЗГ-аа Сэжун гээд хот руу, Сэжун билүү тийм ээ хот руу шилжүүлчихсэн. Гэтэл Сэжун хот руу тийм ээ. Тэнд очингуут бид нар ингээд нөгөө ажлын хэсгийнхэн очсон чинь Сөүлдээ буучаад, тэр хот руу өглөө 2 цаг давхиж очиж байгаа байхгүй юу. Яагаад гэвэл тэнд зочид төлөөлөгчид буух буудал нь байхгүй байх жишээтэй тийм их төвлөрөлтэй.

Тэгэхээр бид нар төвлөрлөө зөв тооцоолохгүй болбол ийм мэт алдаа гаргахгүй байх ёстой. Тэгэхээр 500

мянган хүнээр шилждэг, Улаанбаатар хотын иргэд нь Орхоны хөндий рүү нүүгээд очихоор ачааллаа даахаа байчихаад дахиад л төвлөрөл үүсвэл яах вэ? Тэгэхээр яагаад 500 мянга? Хэдий хугацаанд 500 гэж харж, цаашаа яаж төвлөрлөө хийх юм бэ, төлөвлөлтөө хийх юм бэ л гэж би асуугаад байгаа юм. Баярлалаа.

Н.Энхболд: Нацагдорж 4 номер.

Н.Нацагдорж: Хүн амын энэ шилжилт хөдөлгөөний талаар бас давхар ингээд судалгаанууд хийгээд ингээд тооцоолууд явж байгаа. Энэ 500 мянган хүн бол зүгээр эхний ээлжид тооцоо авах. Ер нь дэлхийн хотууд төлөвлөхдөө ерөнхийдөө 500 мянган хүнээр дунджаар тооцож эхний тооцоогоо авч байгаа. Газар нутгийн хувьд бол энэ ерөөсөө маш том. Улаанбаатар хотоос одоо тэр суурьшлынх нь хэсэг нь бол Улаанбаатар хотоос 3 дахин том буюу 25 мянган га-д хийж байгаа. Тэгэхээр 500 мянга, 1 сая 500 мянган хүн байхад бол асуудал байхгүй. 1 сая 500-аас 2 сая хүн бол тэр хотод амьдрах тийм боломжоор нь төлөвлөж байгаа ер нь бол.

Энд зүгээр хүн амын шилжилт хөдөлгөөнөөс болохоор хүмүүсийг юунаас бүрдэх вэ гэдгийг судалдаг. Уугуул нутгийн иргэд, технологи шинэчлэлт судалгааны, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээний тэр төрлөөс шалтгаалж ирэх хүмүүс, өндөр чанартай нийтийн үйлчилгээнд татагдсан хүмүүс, цөм аялал жуулчлал, өндөр боловсролын тэр байгууллагад татагдаж ирэх хүмүүс гэдгээс ерөнхийдөө бүрдэнэ. Ингээд энэ дээр бол Улаанбаатар, энэ арилчихлаа. Улаанбаатар хотоос бол одоо шууд хот байгуулахад Улаанбаатар хотоос 93 мянган ажлын байр тийшээгээ шилжих бололцоотой. Тэгвэл үндсэн ажлын байрыг дагаад хэчнээн хүн очих вэ гэж байдаг. Энэ бол 213 мянган хүн очих бололцоотой. Мөн 213 мянган.../минут дуусав/

Н.Энхболд: Сарангэрэл гишүүн нэг тодруулагдахъя гэж байна.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Их сайхан манай Нацагдорж архитектуртай туршилагатай баг энэ дээр ажиллаж байгаа юм байна. Тэгээд энэ Даваасүрэн сайд хариулах юм уу, манай архитектур хариулах юм уу? Ер нь хэдэн онд эхнийхээ хүнийг хүлээж аваад ер нь хотын ийм дүр төрхтэй болоод эхлэх юм бэ? Мэдээж шууд 500 мянган хүнийг авчихгүй байх тийм ээ. Ямархуу байдлаар ер нь төсөөлж байгаа юм бэ? Энэ бол их тийм сонирхол татаж байна.

2 дугаарт бол яг улсын нийслэл гээд бид нар өнөөдөр энэ Улаанбаатар хотоо харж байгаа. Сая Жаргалмаа гишүүн ч хэлж байна. Бид нар анх 500 мянган хүнээр тооцоод, тэгээд одоо энэ 2030 онд бол Монголын хүн ам бол 4 сая болно гээд л статистикийн тооцоо судалгаа гарчихсан. 2045 онд бол 5 сая руу дөхнө гээд ийм үе шаттай тооцоонууд байж л байгаа юм билээ. Тэгээд энэ улсынхаа нийслэлд бол өндөр байшин барьдаггүй, үйлдвэрийн газар байдаггүй энэ Австралийн жишээ бий дээ. Тухайлбал Сидней ер нь бол хот байхад Канберра бол ерөөсөө өндөр байшин байдаггүй, засаг захиргааны гол нэгжүүд нь байдаг нэг ийм жишигтэй юм билээ шүү дээ. Бид нар энэ Хархорумаа ер нь хэрхэн яаж төсөөлж байгаа юм бэ? Зүгээр нэг танин мэдэхүйн чанартай. Манай улсын маань нийслэл ямар болох юм бэ гэдэг л ийм л асуулт л даа.

3 дугаарт Даваасүрэн сайд ер нь бүхэл бүтэн улсын нийслэлийг босгох гэж байгаа ажил учраас гаднын улс орнууд, компаниудын сонирхлыг ихээхэн татаж байгаа 400 гаруй компани сонирхож байгаа гэж хэлж байна тийм ээ. Тэгээд мэдээж хэрэг та нар маань нэлээн сайн судалсан байх. Улсын нийслэлийн босгосон туршилагатай ер нь тийм улс орнууд аль нь байна вэ? Тухайлбал усан цахилгаан станцаар бол Хятадыг л гээд байдаг юм байна лээ миний уншиж

байснаар шүү дээ. Нийслэл хот байгуулах ийм туршилага тухайлбал хамгийн сүүлд байгуулагдсан хотуудын талаарх мэдээлэл энэ тэрийг та нар маань авсан уу? Энэ ч, ер нь улс орныхоо чиг баримжаа, туршилага судлах чиг баримжаагаа аль зүг рүү авч байгаа юм бэ гэсэн ийм 3 асуултад хариулт авах гэсэн юм. Баярлалаа.

Н.Энхболд: Хэн хариулах вэ, Нацагдорж хариулах уу? 4 номер.

Н.Нацагдорж: Энэ хүн амын хэдэн онд баригдаж дуусах вэ, хэзээ эхлэх вэ энэ бол хүмүүсийн асуудаг асуулт. Ерөнхийдөө хотын энэ бүтээн байгуулалтын ажил бол сүүлийн жил энэ байдлаар бол ерөнхий 4-өөс, 5-аас 10 жилийн хугацаанд л явагдаж байгаа ер нь бол. Манайх ч гэсэн энэ төлөвлөлтөө хийгээд ингээд явчих юм бол тэр жишгээр л явна гэж тооцож байгаа бид нар. Ер нь хот, ер нь хүн ам нь яаж өсдөг вэ гэдэг асуудлууд байдаг. Хотын хүн ам бол тухайн үндсэн ажлын байраа дагадаг. Одоо Хархорин дээр болохоор болохоор 1700 ажлын байр байгаа. Энийг дагаад тэнд 5400, 5144 хүн байгаа. Тэгэхээр энэ цаашидаа ингээд ажлын байр нэмэгдэх тусмаа 25 онд 3192 ажлын байр бий болгоно. Тэгвэл 7469 хүн бий болно, ингээд 26, 27 гээд ингээд яваад өсөлтүүд нь ингээд явж байгаа юм. Ерөнхийдөө иймэрхүү тооцоонууд байдаг. Энэ мэдээж хөгжлийн ерөнхий төлөвлөгөө гараад ирэхээр илүү нарийвчлагдана гэсэн үг. Тэгэхээр хүн амаа бол ингэж бүрдүүлнэ. Мэдээж бүс нутгийнхаа хүн амыг судалдаг. Бүх аймгийнхаа илүүдэл байгаа тэр ажилгүйдэл, тэр орчин тэр бүх юмыг судалж байж ингээд хүн амынхаа бүрдүүлэлтийг тооцож хийдэг юм.

2 дахь асуудал нь болохоор шинэ нийслэлүүдийн хувьд болохоор түрүүний танилцуулсан манай хотын нэг юу гэсэн нөгөө нэг бүтцийг асуугаад байсан чи тэрийг үзчих. Ямар, ямар байгууллагууд байх юм бэ гээд. Шинэ нийслэлүүдийн хувьд бол Өмнөд Солонгос шинээр барьж

байна, Филиппин барьж байна, Индонез барьж байна, Египет барьж байна, яг одоо бүтээн байгуулалт нь эхлээд ингээд явж байгаа байгууллагууд байна. Хамгийн сүүлийн маш өндөр технологийн хот төлөвлөсөн бол Хятадын Шуньи дүүрэг гэж байгаа. Бээжингээс урагшаа 105км-ийн зайтай байдаг. Энэ бол 17 онд ингээд олон улсын уралдаан зарлаад 279 баг орсон. Эндээс 20 оноос бүтээн байгуулалт хийсэн. Одоо бол 1 сая 300 мянган хүнтэй болсон, бүх асуудлууд нь шийтгэсэн, хамгийн өндөр технологи. Хятадууд бол ерөөсөө дэлхийн хот төлөвлөлтийн хүндрэлийг Хятад улс яаж шийдэхийг харуулах гэж ингээж хийсэн маш том бүтээн байгуулалт явагдсан байна лээ. Зүгээр бид нар бол яг энэ жишгийн дагуу бас олон зүйлүүдийг судалсан.

Тийм учраас ингээд олон улсын уралдаан энийг зарлаад, дэлхийн олон хот төлөвлөгч нар энэ Хархорум хотын бүтээн байгуулалтад төслөө хийж ирэх гэж байгаа юм. Одоо 75 баг бол төслөө хийгээд явж байна явцын дунд 3 сарын хугацаанд хийж байгаа юм.

Энэ хотын бүтцийг асууж байгаа. Хотыг хот бол бид нар 5 зүйлээс бүрдэнэ гэж байгаа юм. 5 салбараас бүрдэнэ тэргүүлэх чиглэл нь болохоор. Засаг захиргааны төв байна, Ерөнхийлөгчийн ордны ордон байна. Ерөнхийлөгчийн ордны ажлын зураг хийгдэж эхэлсэн, байришил тодорхой болчихсон, хийгдээд эхэлж байгаа. Төв талбайн ажил одоо хийгдэхээр ингээд бас ингээд ажлын зураг нь ингээд хийгдээд явж байна. ЗГ-ын яам байна, ЗГ байна, хотын захиргаа байна, ЗГ-ын харьяа агентлагууд байна гэсэн ийм чиглэлтэй. Яагаад гэвэл энд бол уурхай түшиглэсэн хот биш энэ бол. Засаг захиргааны төв байх ёстой Монгол Улсын.

Улаанбаатар хотыг хүмүүс асуудаг. Улаанбаатар хот яах ёстой вэ гэвэл цаашидаа бизнесийн, боловсролын, үйлдвэрлэлийн хот байх ёстой. Энэ бол

тэрүүгээрээ биеэ даагаад хөгжих бололцоотой. Энэ 3 том салбар бол тогтвортой Улаанбаатарыг хөгжүүлэх бололцоотой. Бид нар Улаанбаатараас 300-аас 400 мянган хүнийг ажлын байрыг дагаж тийшээгээ татах л сонирхолтой байгаа. Тэгэх юм бол Улаанбаатар хот өөрөө аягүй гоё болчихно. Зам талбай нь хүрэлцчихнэ, сургууль, цэцэрлэг нь хүрэлцчихнэ, тэр нийгмийн дэд бүтэц, тэр инженерийн дэд бүтэц нь хүрэлцээд эхэлнэ. Илүү орон сууцууд бариад л, илүү ажлын байр хийгээд байх юм бол хүмүүс энд төвлөрөөд л байна. Тэгэхээр тэр асуудлуудыг шийдэх гээд л ингээд л араас нь олон жил явсан, улам л хүндрээд байгаа.

Аялал жуулчлалын салбар бол энд хөгжинө. Яагаад гэвэл энэ чинь байгалийнхаа тогтцоор ч тэр, түүх нь ч тэр, бусад зүйлүүд дээр аялал жуулчлал хөгжих маш их боломжтой. Мөн өндөр технологийн салбарыг ийш нь хөгжүүлнэ гэж байгаа. Энд дэлхийн хотуудад үүсэж байгаа өндөр технологийн тэр үйлдвэрлэлүүд, төвүүд энд үүснэ. Мөн олон улсын харилцааны төв байна. Олон улсын байгууллагууд байна, олон улсын их, дээд сургуулиуд, Элчин сайдын яамнууд байх, олон улсын хурал зөвлөгөөн хийдэг бизнесийн төвүүдийг тэнд хөгжүүлнэ. Энэ бол одоо тэр газар олголт тэр бүх юмаараа дэмжээд хөгжүүлнэ. Мөн эрүүл мэндийн салбарыг тэнд хөгжүүлнэ гэж байгаа. Ер нь бол хотын хамгийн их механик өсөлтийг татдаг 2 салбар байдаг. Энэ бол боловсролын салбар, эрүүл мэндийн салбар. Улаанбаатар хотод их, дээд.../минут дуусав/

Н.Энхболд: Даваасүрэн сайдын микрофоныг өгчихье.

Ц.Даваасүрэн: Тийм бид нар энэ хотын ер нь болбол өнгө үзэмж дүр төрхийг болбол түрүүн хэллээ. Хотын концепцыг боловсруулахдаа болбол дэлхийн тэр өнөөдрийн чиг хандлага ямар байна, тэр шилдэг архитектурын гаргаж байгаа бүтээлтэй уялдуулж

хийнэ гэж байгаа учраас олон улсын нээлттэй тендер зарлаж байгаа учраас энэ бол дэлхийн жишигтэй хот болно гэж. Тэгээд удахгүй юу Ерөнхийлөгчийн Тамгын газраас бас энэ Хархорум хотын хөгжлийн ерөнхий энэ төлөвлөлттэй уялдуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх хуулийн төсөл өргөн барина. Бие даасан хууль гаргана. Тэгээд тэр хуулийн хүрээнд хөрөнгө оруулалтууд яаж хийгдэх вэ, тэр таны асуугаад байгаа байшингууд жишээлбэл төвдөө жишээлбэл тодорхой өндрийн хязгаарлалттай байя гэж байна шүү дээ тийм үү? Тэр асуудлуудыг бол эхнээс нь хууль, эрх зүйн хувьд бол бид нар зохицуулж өгнө. Тэгж байж нөгөө эмх цэгцтэй, зөв төлөвлөлттэй, тэрнийхээ дагуу хөгждөг хот болгоно гэж ингэж бодож байгаа.

Тийм учраас хуулийн төсөл болбол удахгүй өргөн баригдана. Содбаатар дарга бас энэ дээр нэмээд хэлчих байх. Тэгээд бид нар бол яг эрх зүйн орчныг нь бүрдүүлж байж ингэж хот төлөвлөлтөө хийгээд явна гэж бодож байгаа.

Н.Энхболд: Баярлалаа.

Д.Сарангэрэл: Би нөгөө түрүүн асуусан тийм ээ. 500 мянган хүнээр төлөвлөж байгаа гэж. Энэ танин мэдэхүйн ёстой чанартай асуулт шүү. Бүх бүтээн байгуулалтаа хийж дуусгахыг бол мэдээж хүлээхгүй байх тийм ээ. Тэгээд үе шаттайгаар суурьшуулах уу, тэр нүүлгэн шилжүүлэх асуудлаар суурьшилтын процесс ер нь яаж явдаг юм бэ шинэ хотод?

Н.Энхболд: Товчхон хариулчихъя. 4 номер.

Н.Нацагдорж: Тухайн газар дээр хөрөнгө оруулалтыг татах, тэр хотыг сонирхлыг татах, тэгээд бүтээн байгуулалтыг татахад бол нөгөө тэргүүлэх нэг зүйл байдаг ер нь бол. Тийм ч учраас Сэжун бол Засгийн газраа тэнд шилжүүлж байгаа. Шуньи болохоор

Бээжингийн засаг захиргааг тэнд иилжүүлж байгаа. Яг энэ шиг бид нар Ерөнхийлөгчийн институтийг тэнд байршуулна эхний ээлжид. Тэгэхээр энэ бүтээн байгуулалт бол ерөөсөө одоо ажлын зураг нь хийгдэж байгаа болж өгвөл намраас ч юм уу, ирэх жилийн хавраас бүтээн байгуулалтын ажил хийхээр зураг төсөл нь хийгдээд явж байгаа юм.

Тэгэхээр энэ Ерөнхийлөгчийн институт тэнд очно гэдэг чинь ерөөсөө зүгээр Ерөнхийлөгч очих гэж байгаа юм биш. Тэрний чинь дагалдах бусад ажиллах хүч, тэр хүмүүсийн тэр хүмүүсийг дагалдаад дахиад ажлын байр бий болгох, үндсэн ажлын байр хийгээд дагалдах ажлын байрууд, тэр сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хүүхдүүд тэр нь хаана байх вэ гээд ийм бусад бүх юм төлөвлөгдөөд явна. Тэгэхээр эхний ээлжид барилгажих тэр бүтээн байгуулалтын энэ ажлуудын төлөвлөгөөнүүд бас гарчихсан явж байгаа. Тэгэхээр үе шаттай гэдэг маань өөрөө түрүүний танилцуулсан мэдээж хэрвээ хөрөнгө оруулалт сайн байвал дэлхийн жишиг хотууд бол ерөөсөө тэгдэг юм. Эхний 5 жилдээ маш сайн хөрөнгө оруулалтыг улсаас нь дэмжиж өгсөн байдаг. Хуульчлаад дэмжиж. Тэгэх юм бол энэний дараа аяндаа хувийн хөрөнгө оруулалтууд ороод эхэлчихдэг. Гаднын хөрөнгө оруулалт. Тэрэн шиг бид нар бол яагаад ингээд зүтгүүлээд байгаа юм Ерөнхийлөгчийн ордныг зүтгүүлээд байгаа юм гэхээр улсынхаа анхаарлын төвд орж, хөрөнгө оруулалтаа илүү авах, тэгж байж гаднын хөрөнгө оруулалтууд орно.../минут дуусав

Н.Энхболд: Баярлалаа. Их Хурлын 23 оны 7 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын үндэсний хорооны мэдээллийг Даваасүрэн сайд, мөн Бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Нацагдорж нар тогтоолын хэрэгжилтийн явц, ЗГ-аас байгуулсан Үндэсний хорооны ажлын

явцын талаар танилцууллаа. Ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

15.53 цаг

Хоёр.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа орёе. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Ерөнхийлөгч өргөн мэдүүлсэн 5 сарын 13-ны өдөр. Содбаатар дарга хууль санаачлагчийн илтгэлийг танилцуулна. Ажлын хэсэгт нь Тамгын газрын дарга Содбаатар, Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Батрагчаа, Төрийн ёслолын албаны дарга Одмөнх нар оролцож байна. 3 дугаар микрофон өгье Содбаатар даргын.

Я.Содбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улсын төрийн, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн. Мөн зүйлийн 2 дугаар хэсэгт Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, иударга ёс, цог хийморийг илэрхийлнэ. 33 дугаар зүйлийн, 30 дугаар зүйлийн нэг дүгээр хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн гэж тус тус заасан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт эрхэмлэн хамгаалах үндэсний эв нэгдлийн зорилгын хүрээнд ард түмнийхээ эв нэгдлийг бэхжүүлэх зорилт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр мөн тусгасан.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиар Монгол Улсын төрийн сүлд туг, далбаа, тамгыг үйлдэх, дүрслэх, дээдлэн

хэрэглэх журмыг хуульчлан зохицуулж байгаа бөгөөд уг хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт төрийн далбааг байнга мандуулах газрыг тодорхойлж, мөн хуулийн 25 дугаар зүйлд иргэд, өрх, аж ахуйн нэгж байгууллага нь төрийн бэлгэ тэмдгийг гүнээ дээдлэн хүндэтгэж, бүх ард түмний баяр наадам, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ болон бусад үед төрийн сүлд далбаагаа барих, байрлуулах, мандуулах буюу төрийн дуулгыг эгшиглүүлж болохоор заасан юм.

Төрийн далбаандаа хүндэтгэлтэй хандах, түүхт ёс, түүхэн уламжлалаа нандигнан өвлөх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг байнга мандуулах эрх зүйн орчныг сайжруулах. Түүнчлэн төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд дурсгал болгон хадгалуулах, зохицуулах хамрах хүрээг өргөжүүлэх зорилгоор Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулаа.

Хуулийн төсөлд Төрийн далбааг байнга мандуулах газар байрилыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтоож болохоор. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд хүндэтгэлтэйгээр гардуулж өгөх эрх зүйн зохицуулалтуудыг тус тус тусгасан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийн илэрхийлэл болсон төрийн бэлгэ тэмдэг төрийн далбаандаа хүндэтгэлтэй хандах, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр

зүйлийн 21.1-д заасан журмын дагуу ЗГ-т хүргэж санал авсан бөгөөд ЗГ-ын хуралдааны тэмдэглэлд дурдагдсан асуудлуудыг хүлээн авч, төсөлд тусгасан болно. Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Н.Энхболд: Содбаатар даргад баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуулт тавих гишүүд нэрээ өгье. Туршилтын, өнөөдөр шинэ аппарат. Туршилт маягаар. Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Би товчхон асуулт асууя Содбаатар дарга. Сая бид дөнгөж Ерөнхийлөгчийн ордон өргөө нүүх, Шинэ Хархорум хотын тухай ярилаа тийм ээ. Ерөнхийлөгч маань ер нь энэ хуулийн төслийг боловсруулахдаа энэ төрийн сүлд, далбаагаа ер нь хаана байрлуулна гэсэн төлөвлөлттэй орж ирж байгаа юм болов уу?

Н.Энхболд: Содбаатар дарга хариулъя.

Я.Содбаатар: Тэгэхээр энэ хуулийн төсөл бол ер нь манай Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд заасныг нь бид нар нэмэлт, өөрчлөлт оруулахаар оруулж ирж байгаа. Тэгэхээр бид нар нэг хэд хэдэн арга хэмжээ бас төлөвлөж байгаа юм. 1 дүгээрт бол Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн далбааг байнга мандуулах газар байрилыг тогтоож байхаар энэ хуулийн төсөлд орж байгаа юм. Тэгэхээр Монгол Улсад төрийн далбааны өдөр гэж байдаг Улсын Их Хурал баталсан. Энэ бол 7 сарын 10-ны өдөр. Энэ жилийн 7 сарын 10-ны өдрийн юунд бид нар энэ хүүхдийн паркт буюу хүүхдийн паркт 60 метр өндөр төрийн далбааг мандуулах ажлыг бэлтгэл ажил хангагдаж байна.

Ер нь бол дэлхийн АНУ-аас эхлүүлээд, Турк гээд маш олон оронд бол, Киргиз гээд маш олон оронд бол төрийн далбаагаа ингэж хүндэтгэлтэйгээр байнга мандуулдаг тийм хүндэтгэлийн том төрийн далбаа хийсэж байдаг шүү

дээ. Та нар улс орнуудаар явахад бол уулын энгэр эсвэл дурсгалтай газруудад. Тэрэнтэй адилхан Монгол Улс ч гэсэн бас ийм, одоо бол бид нар бол Сүхбаатарын талбай дээр тэмдэглэлт өдөр, баярын өдрүүдэд бол ийм төрийн далбаа гаргадаг. Гадаад, дотоодын зочин хүлээж авахад. Тэгээд энийгээ бол бид нар байнга ингэж мандаж байх 60 метр өндөр төрийн далбаа Ерөнхийлөгч санаачилж ингэж босгохоор болж байгаа.

Мөн энэний дараа бол ирэх жил бид нар бас 120 метр өндөр төрийн далбаа босгох энэ төсөв тооцоо судалгааг хийж байна. Тэгээд ийм байдлаар ер нь бол бас төрийнхөө далбааг байнга мандуулах газар байрилын тогтооё, энэдээ бас дагаад энэ чинь өөрөө маш том бүтээн байгуулалтын ажил болдог. Тэгээд энэ бүтээн байгуулалтын ажлыг нь бас хийе гэсэн ийм. Энийг дагаад ер нь Монголын ард түмний эв нэгдэл, цог хийморь, энэ түүхэн уламжлал гээд олон юманд бол бас их чухал. Улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдалд ч гэсэн их чухал. Ийм үзэл санаа, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чухал алхам болох юм гэж бид үзэж байгаа.

2-т бол энэ төрийн далбааг улс орнуудад бол янз янзаар ингэж дурсгал болгож өгөх янз янзын юу байдаг. Бид нар бол энэ төрийн Их Хурлын дарга, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Аюулгүйн зөвлөлийн гишүүд бол бас энийг хүндэтгэлтэйгээр ингэж өгдөг, энийг бас хуульчилж өгөх гэх мэтчилэн энэ Төрийн далбааны хуульд байдаг зүйлүүдийг нарийвчилж, хүрээг өргөтгөх байдлаар ингэж нарийвчилж заасан ийм хуулийн төсөл оруулж ирж байгаа гэдгийг та бүхэнд хэлье. Ер нь бол бид нар энэ Монголчууд бид нар эх оронч үзлийг төлөвшүүлэх, эх орноороо бахархах, эх орноо сурталчлах энэ юунд бол энэ том алхам болох байх гэж ингэж харж байгаа.

Н.Энхболд: Баярлалаа гишүүд асуулт тавьж дуусаж, хариултаа авлаа. Үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн алга байна. Санал хураана. Хэлэлцэх эсэх асуудлаар. Тэгэхээр ингэе. Баярлалаа Содбаатар дарга. Манай Байнгын хороонд давхар нөгөө Нийгмийн бодлого дээр Оюунчимэг гишүүн байгаа юу тийм ээ? Мөнхөө гишүүн байгаа юу, Жаргалмаа байгаа билүү? Та 2 очоод Нийгмийн бодлого дээр тэднийх нэг санал хураах гэж байгаа юм байна. Тэрэндээ орчхоод хүрээд ир. Бид түр завсарлаж байж байгаад, тэгээд гишүүдээ нөгөө Байнгын хорооноос хүрээд ирэхээр давхардуулаад зарлачихъя. Тэгээд саналаа хураачихъя. Дэмжчихнэ байх гэж найдаж байна. Ажлын хэсэгт баярлалаа.

Түр завсарлачихъя манайх. Хаахгүй, хаахгүй. Нөгөө Байнгын хороон дээр саналаа хураагаад, гишүүд ороод ирэхээр үргэлжлүүлээд бид саналаа хураана.

Хуралдаан Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаан хуралдаж дуусах хүртэл 16 цаг 00 минутаас 17 цаг 04 минутад завсарлав.

Түр завсарлага дууслаа. Нийгмийн бодлогын байнгын хороо хуралдаад асуудлуудаа шийдсэн байна. Бид нар хуралдаанаа үргэлжлүүлэе. Хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн. Санал хураана. Төрийн бэлгэ тэмдгийн тухай Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцээд, асуултдаа хариулт аваад, үг хэлээд дууссан. Одоо санал хураана, гишүүдээ анхааралтай байгаарай.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн, хэлэлцье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Яаж санал хураах билээ хүүхдүүдээ шинэ чинь? Хээгээ, одоо

тэгээд зөвшөөрсөн, татгалзсан гэсэн юм гарч ирнэ. Саяынх туршилт шүү. Оюунчимэгээ санал хураах гэж байна шүү. Одоо ингэнэ санал хураалт гээд тэгэхээр энэ дээр бичиг гараад ирнэ, санал өгөх гээд. Тэгэхээр нь хурууныхаа хээг ингээд, тийм, тэгээд дээдэх 2 үсэг тодрох ёстой. Энэ яагаад гарахгүй байна вэ? Туршилтын санал хураалт, санал хураалт. Хурууныхаа хээг уншуулаарай. 6 гишүүн, 6 гишүүн, Амарсайхан сайдынх гараагүй байна шүү, тийм үү? Одоо болох уу?

Санал хураалт. Одоо анхааралтай байгаарай. Хурууныхаа хээг хийлээ. 7 гишүүн дэмжиж, 63,6 хувиар тухайн хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцье гэсэн дэмжиж саналаа өглөө. Санал, дүгнэлтийг дэвших гишүүдээсээ өгнө. Эндээс эхлээд. Сарангэрэл Ерөнхийлөгчийнхийг тэгээд. Одоо бид нар яагаад яах вэ дээ, үгүй ээ ганц нэг гишүүдээ бас яриулж байя даа. Баярлалаа.

17.08 цаг

Гурав.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд ЗГ-аас 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг явуулна.

Ажлын хэсгийг танилцуулаадахъя би. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэхэд оролцох ажлын хэсэг. Барилга, хот байгуулалтын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баярбат тийшээ суугаарай.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цогтгэрэл тийшээ суугаад байгаарай. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батцэцэг дарга тийшээ суугаарай. НЗД-ын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч Сайнзориг дарга түрүүн байсан хаачив? Сайнзоригийг дуудаарай. Засаг дарга бөгөөд Хотын захирагчийн Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Цолмон. Эдийн засгийн хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр, Эрдэнэбаярыг дуудаарай. Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга Санжаадорж, түрүүн ирчихсэн явж байсан даа, дуудаарай. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Наадуул чинь нэг газар явах шиг байна, ойрхон сая байж байсан.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Сүрэнхорол, тийм. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Тэнгис, Тэнгис. БОАЖЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Баярмаа, ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын шинжээч Төрбат, НЗДТГ-ын Хууль, тогтоомж гэрээ, эрх зүйн газрын дарга Амгалан, Алдаржавхлан Хан-Уулын Засаг дарга, БХБЯ-ны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Билэгсайхан, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал эрхэлсэн захиргааны дарга Батбаяр, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны ерөнхий менежер Гүнболд, Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах хорооны ажлын албаны төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч Батгэрэл, Удирдлагын академийн Улсын салбарын тэнхимийн удирдлагын багш, доктор, профессор Жаргал, Жаргал түрүүн явж байх шиг байсан даа. Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны захирагч Эрдэнэбулган гэж хүн ирсэн үү? Сэлэнгэ аймгийн Дулаанхаан тосгоны захирагч Ганболд. Булган

аймгийн Хялганат тосгоны захирагч Сод-Эрдэнэ. Сод-Эрдэнэ дарга ирсэн юм байна. Ажлын хэсгийг танилцууллаа.

Энэ хуулийн төслүүд дээр ажлын хэсэг гарсан байгаа. Ахлагчаар нь Учрал сайд ажиллаж байгаа. Ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, биш ээ хот, тосгон тийм. Учрал сайд танилцуулна. Учрал сайдын микрофоныг өгье. Өгчхөж.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. ТББХ-ны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдөр төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн билээ. Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Учралаар ахлуулж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан, Батжаргал, Баттөмөр, Дамдинням, Доржханд, Мөнх-Оргил, Мөнхцэцэг, Одонтуяа, Тэмүүлэн нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Ажлын хэсгийн ахлагч хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг холбогдох төрийн захиргааны төв, зарим төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, эрдэмтэн судлаачдын төлөөллийг оролцуулан байгуулж ажилласан бөгөөд нийт 9 удаа хуралдлаа. Ажлын хэсэг 2024 оны 5 дугаар сарын 15 болон 17-ны өдөр хуралдан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төсөлд шаардлагатай зарим зүйл, хэсэг заалтыг нэмэх, төслийн хэсэг заалтыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэх, нэр томъёог тодорхой болгохтой холбогдуулан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэлээ.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол дараах хүрээг хамарсан болно. Үүнд, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор, 1.хот, тосгоны удирдлагын зарчимд төр хувийн хэвилийн түншлэлийг дэмжих. Алслагдсан хот, тосгонд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх. Хот, тосгоны зохион байгуулалт, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, хотын зэрэглэл тогтоохтой холбоотой шийдвэр гаргахад их өгөгдлийн тооцоололд суурилах, дэвшилтэт технологийг ашиглах зарчмыг тусгах.

2.Төсөлд хот, тосгоны хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо, мэдээлэл технологи ашиглах гэсэн зүйлийг нэмж, хот, тосгоны удирдлага нь хот, тосгоны чиг үүргийг хэрэгжүүлэхэд инновац, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, юмсын интернэт зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, шийдвэр гаргахаас өмнө тухайн шийдвэрийг цахим орчинд урьдчилан загварчилж, үр дүнг тооцоолох, дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд зохицуулалтын сэндбокс орчинд туршиж, оршин суугчдын саналыг авах, харилцаа холбоо, мэдээлэл технологийн дэд бүтэц, мэдээллийн системийг бий болгох зэрэг зохицуулалтыг тусгах.

3.Тосгоны удирдлага нь тосгоны зөвлөл, тосгоны Захирагчаас бүрдэх бөгөөд Тосгоны зөвлөл 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх. Зөвлөлийн гишүүн, Тосгоны захирагчийг оршин суугчдаас сонгох.

4.Төсөлд хотын зөвлөлтэй холбогдуулан тусгагдсан зохицуулалттай адил тосгоны зөвлөл бүрэн эрхээ хэрэгжүүлж, анхдугаар хуралдааныг хуралдуулж чадаагүй, төсвөө батлаагүй, хуралдаан зарлаж төвлөсөн хугацаанаас хойш хуралдахгүй 60 хоног өнгөрсөн бол тосгоны зөвлөлийг харьяалах сум, дүүргийн Засаг дарга эсхүл орон нутгийн зэрэглэлтэй хотын захирагч тараах шийдвэр гаргах зохицуулалт дийг нэмж тусгах.

5.Төсөлд тосгон нь зөвлөлтэй байхаар нэмж тусгахтай холбогдуулан төсөлд тусгагдсан Хотын зөвлөлийн чиг үүргээс албан татварын хувь хэмжээ тогтоох, аймаг, нийслэлийн ИТХ үнэт цаас гаргах чиг үүргээ шилжүүлсэн тохиолдолд хотын захирагчийн өргөн мэдүүлснээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу үнэт цаас гаргах, зээл авах зөвшөөрөл олгохоос бусад чиг үүргийг тосгоны зөвлөл хэрэгжүүлэхээр тусгах.

6.Хот, тосгоны захирагчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болохтой холбогдох зохицуулалтын нийцлийг хангах.

7.Хот, тосгонд шаардлагатай үйл ажиллагаа эрхлэхэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар зохицуулахаар тусгах.

8.Хот нь эдийн засгийн тусгай бүстэй байж болох зохицуулалтыг тусгах.

9.Төслийн зүйл, хэсэг, заалтын хоорондын нийцлийг хангах болон бусад хууль тогтоомжийн зохицуулалттай нийцүүлж өөрчлөх зэрэг агуулгыг хамарч байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдтэй холбоотойгоор. 1.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд Монгол

Улсын Үндсэн хуульд заасан тосгоны өөрийн удирдлагатай байх заалтад нийцүүлэн Тосгоны зөвлөлийн чиг үүргийг тусгасантай холбогдуулан дагах хуулийн төсөлд Тосгоны зөвлөлийн хариуцах чиг үүргийг тусгалаа.

2.Орон нутгийн өмчийн харилцаанд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 68.4-д заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн ИТХ-ын бүрэн эрхийг тухайн Хот, тосгоны зөвлөл хэрэгжүүлэхээр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төрийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн бол Засаг даргын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны захирагч хэрэгжүүлэхээр тодорхой тусгалаа.

3.Хот байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтад заасан нийслэл Улаанбаатар хотын улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хотын эдэлбэр газрын хэмжээ заагийг бусад улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хотын эдэлбэр газрын хэмжээ заагийг тогтоох асуудлаар Улсын Их Хурлын шийдвэрийн төсөлд хамтатган боловсруулах нь зүйтэй гэж үзлээ.

4.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Гамигеас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах нь зүйтэй гэж шийдвэрлэлээ.

5.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан ус бохирдуулсны төлбөрийн орлогын 50-аас доошгүй

хувийг усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд, 50-аас доошгүй хувийг хотын дэд бүтцийн санд төвлөрүүлж, цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд зарцуулахаар тусгагдсаныг хууль хэрэглээнд зөрчил үүсгэхгүйн тулд 50, 50 хувь байхаар өөрчиллөө.

6. Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын алслагдсан байриилд тухайн хотын газрын зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссаны дагуу баригдсан олон улсын стандартад нийцсэн боловсрол, соёл, нийтийн номын сан, нийгмийн халамжийн үйлчилгээ, ахмадын төв, эрүүл мэндийн анхан шатын тусламж үйлчилгээний төв, спортын барилга байгууламжийн үл хөдлөх эд хөрөнгөд ноогдуулах албан татварын хэмжээг 5 жилийн хугацаанд чөлөөлж болох зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй гэж үзлээ.

7. Тосгоны захирагчийг төсвийн ерөнхийлөн захирагч байж өөрөө тосгоны төсвийн төслийг боловсруулж, тосгоны зөвлөлд өргөн мэдүүлж, зөвлөлөөрөө батлуулдаг байх зохицуулалтыг нэмж тусгалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Н.Учрал: Учрал сайдад баярлалаа. Санал хурааж эхэлнэ. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Ингээд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн I дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Зүйлүүд дээр ажлын хэсгээс санал гарсан бол би

тухай бүрд нь уншаад санал хураалгаад явчихна. 2 дугаар зүйл дээр саналтай, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

3 дугаар зүйл дээр ажлын хэсгээс гарсан санал байгаа. 1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Нийслэл Улаанбаатар хот, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын тухайлан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Учрал, Бат-Амгалан, Батжаргал, Баттөмөр, Дамдинням, Доржханд, Мөнх-Оргил, Мөнхцэцэг, Одонтуяа, Тэмүүлэн, цаашид ажлын хэсэг гэнэ. Нэлээн том ажлын хэсэг гарсан. 8, 9 удаа хуралдсан гэж сая илтгэсэн. Тэгэхээр асуудлуудаа нэлээн сайн цэгцэлсэн байх гэж бодож байна. Ер нь маргаантай нэлээн зүйлүүд энэ хуулиар орж ирж байсан шүү. Саяын томъёоллоор санал хураалт. Нөгөө хэн, нөгөө 2 гишүүн хаачив? Энэ туршилтынх шүү. Жаргалмаа, хэн 2-ыг, Сарангэрэл 2-ыг дуудаадах. Энийг хүчингүй болголоо. Хүрнэ, 10 хүн, тийм 6-гаар. ТББХ-ны гишүүд хуралдаандаа ирж оръё. Сарангэрэл гишүүн, Жаргалмаа гишүүн, Оюунчимэг, өөр бүртгэлд орчихсоноос хэн байна вэ? Тогтохсүрэн гишүүн, Пүрэвдорж гишүүн уг нь байсан юм сан. Жаргалмаа, Оюунчимэг, Сарангэрэл гишүүд хуралдаа ирье, санал хураах гэж байна. Энүүгээр зарлаж байна шүү дээ. Сарангэрэл гишүүн, Оюунчимэг гишүүн, Жаргалмаа гишүүд хуралдаа ирж, саналаа өгье.

Найруулах, 3.1.Нийслэл Улаанбаатар хот, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын тухайлан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна гээд ажлын хэсгийн гаргасан санал байгаа. Үүгээрээ нэг хураагаад үзье, санал хураалт. Ер нь ингэе. Би нэг горимын санал гаргая. Энэ бас ингээд нэлээн удаад байх юм, нааш цаашаа нөгөө шинэ техник болохоор. Тэгэхээр бид нар шууд гараа өргөөд

явчихъя тэгэх үү? Цаг алдахгүй. Гараа өргөөд явчихъя тэгэх үү, дэмжих үү? За. Тэгвэл саяын санал хураалтаар, саяын уншсан томьёолоор санал хураалтыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөе. 6. 2 төслийн 4 дүгээр зүйлийн, 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “оршин суугчтай,” гэсний дараа “эсхүл байнгын оршин суугчтай байхаар төлөвлөсөн,” гэж нэмж, 4.3 дахь хэсгийн “эдийн засаг, нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, хэрэгжүүлэх” гэснийг “болон бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, газар зүйн байршил,” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн санал, дэмжье. 6-аас, 11-ээс 7.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дангаараа” гэснийг “нэг” гэж, 5.5 дахь хэсгийн “энэ хуулийн 5.2-т заасныг” гэснийг “тосгоны оноосон нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршил, заагийг” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн. 7, 11-ээс 7.

4.Төслийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.9, 6.1.10, 6.1.11 дэх заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“6.1.9.төр, хувийн хэвилийн түншлэлийг дэмжих;

6.1.10.алслагдсан хот, тосгонд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх;

6.1.11.хот, тосгоны зохион байгуулалт, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, хотын зэрэглэл тогтоохтой холбоотой шийдвэр гаргахад их өгөгдлийн тооцоололд суурилах, дэвшилтэт технологийг ашиглах.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье.

7 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна. Таны микрофон өгчихлөө. 7.

С.Амарсайхан: Энэ 7.1 дээр нэг асуулт байна. Хот нь хуульд өөрөөр заагаагүй оршин байгаа тухайн аймаг эсвэл нийслэлд харьяалагдана гэж байгаа. Тэгэхээр улсын зэрэглэлтэй хот жишээ нь юунд харьяалагдах вэ? Улаанбаатарт харьяалагдах юм уу? Дархан, Эрдэнэт улсын зэрэглэлтэй болчихлоо гэхээр аймагтаа харьяалагдах юм уу энийг юу гэж ойлгох вэ? Налайх, Багануур улсын зэрэглэлтэй болчихоор улсын нийслэл Улаанбаатарын харьяа Налайх улсын зэрэглэлтэй хот гэж явах уу гэж ойлгох уу? Энэ дээр нэг тайлбар өгчих.

Н.Энхболд: 3 номер.

П.Сайнзориг: Орон нутгийн зэрэглэлтэй хотууд, ялангуяа магадгүй, зүгээр жишээ аваад ярихад Шинэ Зуунмод хот гээд дагуул хот байх юм бол бас тухайн орон нутагтаа харьяалагдах, магадгүй жишээ нь Дархан дээр Шарын гол гээд хот байгууллаа гэж тооцох юм Дарханд харьяалагдана гэсэн үг. Яг таны асууж байгаа улсын зэрэглэлтэй хотын хувьд бол бас та өөрөө нөгөө саналаа гаргасан бас сайд мэдэж байгаа байх. Тэгээд ер нь яах вэ нэгэнт Налайх, Багануур хоёроо улсын зэрэглэлтэй хот болгож байгаа учраас энэ шийдлийн хувь дээр бол үндсэндээ Нийслэлийн харьяанд гэдэг юм уу, Нийслэлд харьяалагдана л гэж бас тайлбарлаж болно. Тэгэхдээ харьцангуй энэ хуулиар бие дааж төсвийн эрх мэдэлтэй, тэгээд улсын зэрэглэлтэй хот болж байгаа учраас дээд шатын захирагч эсвэл Ерөнхий сайд улсын зэрэглэлтэй хотыг томилохоор байгаа иргэдийн саналыг батламжлах байгаа. Тэгэхээр үүгээрээ харьцангуй бие даасан ийм байдалтай өөрийн үйл ажиллагаагаа явуулна гэж хэлж болно.

Н.Энхболд: Тэгээд харьяалалд байна гэдгийнх нь утга учир нь юунд

байгаа юм, яах гэж харьяалж байгаа юм бэ? Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Нийслэл чинь нөгөө засаг захиргааны нэгжээрээ хэвээрээ байж байгаа шүү дээ. Тэгэхээр тэр засаг захиргааны нэгжид газар нутгийнхаа юунд засаг захиргааныхаа нэгж дотор байж байгаа л хот гэсэн үг байгаа байхгүй юу. Нэгжийнхээ хувьд харьяалагдана. Ахуйн ажил, захиргааныхаа ажлаас гадна ахуйн ажлынхаа юмнуудыг нийслэл нь, хот нь өөрөө хийнэ. Тэгээд уг нь энэ дээр бид нар яг юун дээр хамгийн сүүлчийн хувилбараараа сайн сууж уу, үгүй юу. Энд ерөөсөө гэрээний ажил, гэрээнүүд л байгуулагдах ёстой юм байна лээ ер нь бол. Нийслэл жишээ нь засаг захиргааныхаа нэгжийн хувьд ямар ажлаа хотод шилжүүлэх вэ, ямар ажлаа өөр дээрээ авч үлдэх вэ гэдгээ. Жишээ нь Налайх хот бол арай том хот учраас засаг захиргааны нэгжид харьяалагддаг төрийн үйлчилгээний олон ажлыг хот өөр дээрээ авчгаж болж байгаа байхгүй юу тийм ээ.

Багануур гэхэд арай жижигхэн учраас нэлээн их ажил нь нийслэлдээ үлдээд, зарим ажлыг нь Багануур дээр авч болж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ яг улсын хэмжээний хот болчихлоо гээд бүгдээрээ адилхан байх бололцоогүй юм байна лээ. Янз янзын нөгөө хотын хэмжээ дамжаа, төсөв хөрөнгө мөнгө, хүн ам, хүчин чадал, захиргааны бололцоо энэ тэрийг нь харгалзаж байгаад тэр үүрэг функцүүдийг нь тэр гэрээгээрээ салгаж өгөх юм байна лээ. Тэнд л нэлээн их тийм хуульчдын том, том багууд гарч л, гэрээгээ байгуулаад, тэгээд дараа дараагийн хотын удирдлагуудад зааж тайлбарлаж ийм гэрээ хийвэл ингэх юм байна, энийг нь хот өөрөө авч үлдэх ёстой юм. Жишээ нь юу гэдэг юм зарим газар бүүр цэрэг татлагаа хүртэл тийм ээ хотдоо шилжүүлчхэж байгаа байхгүй юу, том хотуудад бол цэрэг таталгаа хүртэл шилжүүлж байна. Зарим газар зөвхөн хог, цэцэрлэг, сургууль, гудамж энэ тэр гэсэн асуудлаа шилжүүлчхээд,

үлдсэн бүх асуудлыг нь засаг захиргааны нэгж нь аваад үлдчихэж байгаа байхгүй юу. Тэгж л бид нар ер нь тайлбарлаж, ойлгож явж байгаа шүү дээ.

Эрдэнэт, Дарханыг болбол уг нь ажлын хэсэг дээр яриад юу л болгочих ёстой байсан юм. Даанч Үндсэн хуульд л нэмэлт оруулах болчихоод байгаа юм. Эрдэнэт, Дархан хоёрыг болбол Улаанбаатар нийслэл шиг засаг захиргааны тусад нь нэгж болгочихмоор юм байна лээ уг нь. Тэгээд 21 аймагтай, 3 том хот нь захиргааны, засаг захиргааны тусдаа нэгжүүд, тэгээд салаад явчих юм бол нийслэл ингээд тус тусдаа хот гарч байгаатай адилхан Эрдэнэт, Дархан ч гэсэн засаг захиргааны аймагтай адилхан том нэгж болоод, дотроо өөрөө бас жижиг, жижиг хот болоод хөгжөөд явчих бололцоонууд нь гарах юм байна лээ. Гэхдээ тэрийг одоо хийх гэхээр даанч Үндсэн хуульд, Эрдэнэт, Дархан гэж нөгөө засаг захиргааны нэгжийг болгоогүй байхгүй юу.

Н.Энхболд: Амарсайхан сайд тодруулъя.

С.Амарсайхан: Энийг илүү жоохон нарийвчилж тодорхойлмоор байгаа юм энэ заалтыг. Одоо яг энэ хэлбэрээрээ явчих юм бол энэ өөрөө явцын дунд нэлээн ойлгомжгүй байдал үүсэх нь. Магадгүй хот, тосгоны хувьд засаглалын хямралд ч оруулах ийм нөхцөл байдал руу орно. Жишээ нь, Налайх, Багануур улсын зэрэглэлтэй хот болчихсон захирагчаа сонголоо. Захирагчийг сонгогдсоны дараа улсын зэрэглэлтэй хотын захирагчийг Ерөнхий сайд томилно гэж энэ заалтад, хууль дээр батламжилна гэж тийм, батламжилна.

Хот орон нутгийн зэрэглэлтэйг болбол тухайн дээд шатны захирагч томилно, батламжилна гэсэн байгаа. Тэгээд ийм заалттай өөр заалт энэ хот хууль дээр явж байхад 7.1 дээр энэ хэлбэрээр нь аймаг, нийслэлд

харьяалагдана гээд заачих юм болбол энэ өөрөө энэ хуулийг хэрэгжих боломж нөхцөлийг бүрдүүлэхгүй, захирагчаа сонгож чадахгүй. Нэгэнт улсын зэрэглэлтэй хот болж байгаа бол энэ бие даасан нэгж болж л явна шүү дээ.../минут дуусав/

Н.Энхболд: Саяын тэр нөгөө Үндсэн хуультай зөрчилдсөн гэсэн юм нь гарах байх л даа. Сайнзориг нэг тайлбар хэлээдэх үү.

П.Сайнзориг: Мөнх-Оргил дарга бараг ер нь гол санааг нь хэлчихлээ. Тэгэхдээ яг сая Мөнх-Оргил даргын хэлж байгаа зохицуулалт маань Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр орж байгаа, 68 дугаар зүйл дээр яг тодотгож гэрээ байгуулах асуудлууд нэлээн орж байгаа. Өөрөөр хэлбэл засаг захиргааны нэгжийн чиг үүргийг шилжүүлэхдээ гэрээ байгуулах асуудал орж байгаа.

Яг Амарсайхан сайдын яг энэ дээр бол бас тодорхой зүгээр юмнууд бас цаашдаа бол анхаарах л, яг л Мөнх-Оргил гишүүний тайлбарыг л хэлэх гээд байна л даа. Би бас яг тэгж шууд хэлэх бас эрх бүхий этгээд биш учраас бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай гэхэд бас арай тэгж тайлбарлаж болохгүй байх. Ер нь болдог бол бас тодорхой хэмжээний энэ өөрчлөлтүүд орвол яг таны хэлж байгаа бүх юм илүү их тодорхой болох юм Шадар сайдаа.

Ер нь зүгээр яах вэ нэгэнт бид хэд бол анх Налайх, Багануурыг орон нутгийн зэрэглэлтэй хот болгож байсан. Тэгээд бас нөгөө таны саналаар улсын зэрэглэлтэй хот болж байгаа. Тэгэхдээ бид хэд бас ингэснээрээ бас нийслэлээс шууд хутгалдаад байна гэсэн үг бол биш. Бид нар тэр 68 дугаар зүйлд заасан гэрээгээ байгуулна. Төсвөө болон бусад юмаа бие даагаад хэрэгжүүлнэ. 1 дүгээрт яах вэ Налайх, Багануур маань нийслэлийн нутаг дэвсгэр дээр байгаа учраас тэгээд зайлиггүй нийслэлийн

харьяалал гэж явахаас өөр аргагүй байдалтай байгаа юм өнөөдрийн орчин дээр.

Н.Энхболд: Нэгжийн хуулиар зохицуулагдана гэж ойлгож байгаа юм байна. Хэрэв зүгээр энийг илүү Амарсайхан сайд санал, зарчмын зөрүүтэй санал өгч болно. Тийм. Тэгвэл бичээд өгчих.

С.Амарсайхан: Хууль баталчхаад, дараа нь хуулиа гэрээгээр зааж хэрэгжүүлнэ гэдэг ийм дампуу юм хийж болохгүй л дээ. Тэгвэл бид хууль батлахын хэрэг юу байгаа юм бэ? Тэгээд тэр гэрээ чинь өөрөө ямар ч эрх зүйн чадамжгүй л орчин нөхцөлийг бүрдүүлнэ шүү дээ. Ялангуяа улс төржилт явагдах юм болбол гэрээ байгуулахгүй гээд гэдийгээд суучихдаг. Хотынх нь ч ажилд явдаггүй, иргэдийнх нь ч асуудалд шийдэгддэггүй ийм өвх ч биш, булчирхай ч биш заалт энд оруулж болохгүй энийг. Яг энэ 7-гийн энэ дээр би болбол зүгээр орон нутгийн зэрэглэлтэй хот өөрөө хуульд өөрөөр заагаагүй оршин байгаа аймаг, нийслэлдээ харьяалагдана л гэж. Нэгэнт улсын зэрэглэлтэй байгаа бол ингэж л бид асуудлуудаа шийднэ. Түүний харьяа наадхын чинь дагуу дараа нь хуульд өөрчлөлт оруулах нэмэлт асуудлууд дагалдах хуулийн өөрчлөлтүүд байвал тэрүүгээр ярьж явж болно. Тийм. Тэгээд энийг би тийм зарчмын зөрүүтэй санал гаргаж байна. Ингэж ийм том хууль баталчхаад, дараа нь гэрээгээр үйл.../минут дуусав/

Н.Энхболд: Та хэрэв яавал санал томъёолоод өгч болно. Тэгэхдээ энэ хар даа Амарсайхан сайдаа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн, Үндсэн хуулийн 4 дүгээр бүлэг дээр 57.2 дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон, нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэхчхсэн нэг ийм заалт байгаа юм байна. Энэдээ л

уялдуулсан гэж бодож байна. Юу ч гэсэн томъёолчих. 7 дугаар зүйлээ түр орхичихъё. 7 дугаар зүйлийг түр орхиод, эндээс санал хүлээж байя.

8 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал байна. 5.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Хотын” гэснийг “Хот, тосгоны” гэж өөрчилж, 8.4 дэх хэсгийг хасах ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн гишүүд гараа өргөв. Гараа. 7. Тийм хотын гэснийг чинь хот, тосгоны гэж хоёулан дээр нь дүрэмтэй болгоё гэж байгаа юм. Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Энэ хуучин хот дээр ажиллаж байгаа энэ тэр БХБЯ-наас л бараг хэлэх байх. Энэ яах вэ хот гэдгийг тосгоны хот, тосгоны дүрэм болгоод л өөрчилж байгаа гээд байгаа. Өнөөдөр нөгөө нийслэлд харьяалагдахаас бусад хот, тосгоны дүрэм дараах харилцааг зохицуулна гээд ингээд заалтууд өнөөдөр ч үйлчилж байгаа зүйлүүд байгаа л даа. Тэрний дотор 8.2.6 нийтийн зориулалттай эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт энэ тэр гээд л. Одоо жишээлбэл нөгөө нэг Бага тойруу буюу 40, 50 мянгат энэ Бага тойруугийн байшин сав гэхэд эргэн тойрон нөгөө нийтийн эзэмшлийн талбайд том, том янз янзын ашиглахгүй байшингууд ч юм уу, дүнзэн амбаар есөн шидийн юм бариад тэр чигээрээ 10, 20 жил болчихсон. Тэгээд нөгөө нураах гэхээр хэн нэгний эзэмшилд байдаг Алимаа, Дулмаагийн гэдэг юм уу. Тэгээд тэр хүмүүст нь нэг уг нь бол тэр хүмүүс энэ нийтийн эзэмшлийн талбайд барилга байшин юм уу зөвшөөрөл авчхаад, 2 жил ашиглаагүй бол буцааж лицензийг нь хурааж авах энэ тэр гээд уг нь дүрэм одоо байдаг шүү дээ тийм ээ.

Тэгэхээр одоо энэ дүрэм чинь үйлчлэхгүй, энэ ёстой үнэхээр замбараагүй юм байна лээ шүү дээ энэ жишээ нь Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо, 5 дугаар хороо гээд. Сайнзориг дарга мэдэх байх. Тэр 6 дугаар хороонд 1-ийг нь нураах гээд л 24-ний дотор гээд л ярьж байна. Тэгэхдээ энэ бүүр

зохицуулалтгүй болчихсон байна лээ шүү дээ. Тэгэхээр одоо нэгэнт л ийм хууль гаргаж ирж байгаа бол энэ, энэ тэрээ зохицуулаад явчихвал яасан юм бэ? Яг 2 жил энийг ашиглаагүй бол эзэн нь яахгүй бол энийг тэдний дотор сануулаад, тэгнэ энэ тэр гээд явчихгүй бол зүгээр шууд, шууд автоматаар яагаад явчхаж байгаа юм байна нөгөө хот байгаа дүрмээ хот, тосгоны гэж байгаа болохоор автоматаар тэрийг нь оруулаад л явчхаж байгаа юм байна шүү дээ. Энэ чинь тийм шинэ хууль, шинэчилсэн найруулгаар орж ирж байгаа шүү дээ. Тэгээд бас одоо тулгараад байгаа асуудлаа давхар шийдлийг нь хийгээд явчихвал их зөв юм биш үү? Хэн хариулах юм бэ? Мөнх-Оргил дарга уу, Сайнзориг дарга 3 дээр.

Н.Энхболд: Учрал гишүүний ажлын хэсгийн ахлагчийн микрофон өгье.

Н.Учрал: Энэ 8 дугаар зүйл дээр нөгөө хот, тосгоны дүрэмд дараах харилцааг тусгаж болно гээд яг 8.2-оос 8.22 хүртэлх яг энэ Оюунчимэг гишүүний яриад байгаа бүх асуудлуудыг дүрэмдээ тусга гэдгийг нь заагаад өгчхөж байгаа юм. Тэгэхээр энэ асуудлууд болбол дүрэмдээ тусгачихсанаараа хэрэгжинэ.

Сая тэр асуугдаад байгаа 8.3 дахь хэсгийн хотын гэснийг хот, тосгоны гэж өөрчлөөд, 8.4-ийг хасах гэдэг болбол энэ хуулийн төсөл дээр болбол анх тосгон зөвлөлгүй байхаар тусгагдсан байсныг ажлын хэсэг дээр яриад тосгон бас өөрийн зөвлөлтэй байна, тосгоны Захирагчийг бас иргэд сонгоно. Зөвлөлөөрөө төсвөө батлаад ингээд явах ийм зохицуулалттай болбол болж байгаа. Тийм учраас хот ч бай, тосгон ч бай өөр өөрсдийн дүрэмтэй. Дараах дүрэмдээ болбол дараах харилцаагаа болбол зохицуулна. Мэдээж дүрмээ Захиргааны ерөнхий хуулийн дагуу тэгээд л бүртгүүлээд л явна гэсэн үг л дээ. Тэгэхээр мэдээж нөгөө хот, тухайн орон нутгийн чанартай хот, тухайн тосгон болбол яг таны хэлж байгаагаар өөр өөрийн ийм онцлогтой учраас тэр

дүрмээрээ тухайн харилцаануудыг зохицуулах эрхийг болбол дүрмээрээ авна. Дүрэмдээ заавал эдгээр асуудлуудыг тусгаж өг гэдгийг 8.2 дугаар зүйл дээр болбол бас тусгаж өгсөн.

Н.Энхболд: Одоо 8.3 дахь заалтыг яриад байна шүү дээ. Тийм. Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Миний асуугаад байгаа юм бол одоо тулгараад байгаа асуудлууд байгаад байна шүү дээ. Энэ зүйлүүд бүгд байгаа. Одоо яах вэ нөгөө хуульд ийм нэр нь өөрчлөгдөж байгаа учраас өөр өөрийн хот доторх хорооллууд өөр өөрийн дүрэмтэй байгаад л энэ нийтийн эзэмшлийн газрууд энэ хайс, хашаа стандарт, түүнийг барьж ашиглах, буулгахыг өөр өөрөө тогтоогоод явчихна гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр чинь бүүр замбараагүй юмнууд болчихно биз дээ. Нөгөө нэг Сэлбэ хотхон өөрийнхөөрөө, Баянхошуу нь өөрийнхөөрөө юм уу, Багануур нь өөрийнхөөрөө тогтоогоод явчихна гэсэн үг биш биз дээ?

Тэгэхээр саяын нөгөө нэг миний жишээ нь энэ саяын 10, 20 жил ашиглахгүй нийтийн эзэмшлийн талбайд зүгээр л ингээд нөгөө үхмэл бараг аймгийн юм шиг л барилгууд бариад, хаяад явчхаад байна шүү дээ. Тэгэхээр тэрийг энэ ашиглалт нийтийн эзэмшлийн газар талбай дээрх ашиглалт, хамгаалалт гээд энэ дээр байж байна шүү дээ. Энэний хэрэгжилт дээр гацаад тулгараад байгаа юман дээр бид энэ дээр шийдлийг нь шууд заагаад өгөөд явчихвал яасан юм бэ л гэсэн асуулт минийх байгаад байгаа байхгүй юу.

Н.Энхболд: Үгүй ээ, яаж заах вэ жишээлбэл?

М.Оюунчимэг: Яаж тэрийг зохицуулах юм бэ тэгээд?

Н.Энхболд: Тэртээ тэргүй энэ заалтаар чинь 8.2.6 хариуцуулчихсан байна шүү дээ. Тийм.

Ц.Мөнх-Оргил: Байшин болгон чинь өөр шүү дээ Оюунчимэг. Тэрийг чинь Засаг дарга, тэрийг чинь шийдэх гээд ингээд улсын тосгоны чинь зөвлөл байж байна, тэрийг чинь шийдэх гээд л ингээд тосгоны Засаг дарга чинь байж байна. Нэг байшин чинь цэцэрлэгийн байшин, нөгөөдөх нь эмнэлгийн байшин, нөгөөдөх нь сургуулийн байшин, нөгөөдөх нь орон сууцын байшин тэр болгоныг яг ийм байлгана шүү гэж бид нар.../үг тасрав/

М.Оюунчимэг: Биш ээ биш, нийтийн эзэмшлийн талбай гэдэг чинь нэг л стандарт байгаа шүү дээ. Одоо дүүрэг тэрийг мэдэхгүй, Нийслэлийн газрын алба л мэднэ гэж байгаа байхгүй юу.../үг тасрав/

Н.Энхболд: 3 номер ажлын хэсэг Сайнзориг.

П.Сайнзориг: Оюунчимэг гишүүнээ ийм байгаа юм. Нөгөө нийтийн зориулалттай орон сууцын хувьд тусдаа хуультай. Энийг засаж болох уу, сэргээх үү яах вэ ийх вэ гэдэг, дахин буулгаж байгаад. Нийтийн эзэмшлийн талбай дээр бол юу гэдэг юм байгаа тоноглол автобусны буудал ч юм уу энэ асуудал. Таны яг ярих гээд байгаа жишээ бол магадгүй нийтийн эзэмшлийн талбай гэхээсээ илүү хувийн өмч байгаад байгаа байхгүй юу. Бид хувийн өмчийг бас яг иргэдтэй нь зөвшилцөж явдаг. Нөхөн олговортойгоор хийх үү эсвэл газрыг хууль бусаар ашиглаад дээр нь барилга барьчихсан байвал угаасаа Газрын хуулиараа зохицуулалттай байхгүй юу. Албадан буулгаад л явна. Тийм. Тэгэхээр энэ ерөөсөө нөгөө Газрын хуулиараа явчхаж байгаа. Тэгэхээр та бас нөгөө санаа зовох хэрэггүй. Энэ бол зөвхөн юу гэдэг юм нийтийн эзэмшлийн гудамж талбай буюу автобусны талбайн тоноглолуудыг яаж ашиглах юм, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын юмнуудыг яаж ашиглаж хамгаалах вэ гэдэг зүйлүүд байгаа.

Таны кэйсүүд бол уг нь тухай бүрдээ Газрын хууль болон холбогдох хуулиудаар шийдэгдээд явах бүрэн бололцоо байгаа. Яах вэ зүгээр бодит практик дээр хэцүү байдаг. Ойлголцоно, зөвшилцөнө, тэр бас хүний хувийн өмч байдаг учраас бас нөхөн олговор үнэлгээний асуудал гээд л яваад байдаг ийм зүйл байгаа.

Н.Энхболд: Санал хураалт. Хотын гэснийг хот, тосгоны гэж өөрчлөөд, 8.4 дэх хэсгийг хасъя гэснийг дэмжиж байгаа гишүүд гараа өргөө. Амарсайхан гишүүн, та 2 дэмжихгүй байгаа юм уу? Баярлалаа. 11-ээс 7 гишүүн дэмжлээ.

7 дугаар зүйл дээр түрүүн энийг ярьчихсан, энд томъёолж байгаа. 8. 9 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна.

6.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Хотын” гэснийг “Хот, тосгоны гэж өөрчилж, мөн зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж дугаарлалтыг өөрчлөх:

“10.2.Тосгоны удирдлага дараах тогтолцоотой байна:

10.2.1.тосгоны Зөвлөл;

10.2.2.тосгоны Захирагч.”

гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжжэ гэсэн гишүүд гараа өргөө. 11-ээс 7.

11 дүгээр зүйлийн, би эхлээд энэ саналаа хураалгая. 11 дээр асуулт, саналтай гишүүн байвал юу. 10-ыг сая хураачихсан шүү дээ. Хураачихсан тийм. Сая 10-ыг хураасан.

11 дүгээр зүйлийн, би санал томъёоллоо уншаадахъя. 11 үү, асуулт. Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Түрүүний асуудал дээр би дахиад маш тодорхой хэлчихье. Аль нэгэн улсын зэрэглэлтэй хот нийслэл, аймгийн харьяанд байж болохгүй. Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Энэ

Үндсэн хуулиар тодорхойлсон асуудал. Үндсэн хуулийн протоколд ч байж байдаг. Тэгээд манай хотынхон бас сайхан хот болгож өгнө гэж хэлээд хонины сүүл дотор сайхан зүү тэвнэ хийгээд, дээрээс нь хөвөн порлоноор ороож байгаад хөөрхөн, хөөрхөн заалтууд энд бас оруулчихаад ингээд дараа нь нэг хот ч болж болдоггүй, тосгон ч болж болдоггүй, хүмүүс нь хохирсон, иргэд нь цөхрөнгөө барсан, эргээд нэг шинэчлэл ч биш, юу ч биш юм болгох л юмнууд их энд хийж дээ.

Тэгээд энэ 11 дүгээр зүйлийн, 11 дээр би бас өмнө нь хараагүй, ингээд л хараад хальт харж байхад асар олон асуудлууд байна. Энэ улсын зэрэглэлтэй хотын хороог хамгийн багадаа 10 мянгаас доошгүй оршин суугчтайгаар байгуулна гээд байж байгаа юм. Тэгэхээр энэ дотор тэдэн хороо гэсэн тоо байна уу, байхгүй юу? Зарим нь 3 мянга гээд бас биччихсэн юмнууд ч байх шиг байна. 8 мянгаас доошгүй оршин суугчтайгаар байгуулна гээд. Тэгэхээр заавал энийг ингэж доод тоог нь ийм өндөр тогтоох шаардлага байгаа юм уу? Ялангуяа энэ алслагдсан дүүрэг, хөдөө аймаг орон нутагт, аймгийн төвүүдэд нэг хороо байгуулаад аль болох хороог төрийн үйлчилгээг иргэддээ ойрхон байх, төвөг чирэгдэлгүй, ил тод нээлттэй байлгах л асуудлыг бид нар 20 минутын хот л гэж яриад байгаа шүү дээ. Тэгээд тэр концепцтойгоо энийгээ яаж уялдуулж байгаа юм бэ? Энэ яг ямар үндэслэлээр гарсан тоо вэ? Энэ дээр Сайнзориг дарга нэг хариулт өгөөч.

Н.Энхболд: 3 номер Сайнзориг.

П.Сайнзориг: Нөгөө эхний асуудал дээр уг нь Шадар сайдаа бид хэд нөгөө Үндсэн хуулийнхаа л заалтад хашигдаж байгаа. Нэгж дээрх л улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот байна л гэж байгаа. Тэгэхдээ бид хэд энэ хүрээндээ байгуулчихаад, улсын зэрэглэлтэй хотыг заавал удирдах гээд байгаа зүйл байхгүй. Иргэд нь захирагчаа сонгоно, Ерөнхий сайд батламжлаад

явах, төсөв нь бие даасан байна гээд бид хэд энэ хуулиараа хийж байгаа. Энэ хуулийн зүйлийн хувьд бас яах вэ бид хэд бас нөгөө Тогтохсүрэн гишүүний ажлын хэсгийг боловсруулж байсан хуулийг бас, хуулийн төслийг бол бас суурилсан. Энэ хууль дээр бас энэ заалтуудыг ерөнхийд нь авсан байгаа.

2 дугаарт ер нь зүгээр Улаанбаатар хотынхоо хэмжээнд энэ хот хороонуудыг авч үзэхэд доод тал нь 10 мянгатай ер нь бол хороод нэлээн дундаж байгаад байгаа, дундаж байгаа. Ингээж байж бас хүн амын тодорхой нягтаршил төвлөрөл л байж тэнд зарим үйлчилгээг хийх зах зээл гэх юм уу ерөнхий тийм хэрэгцээ бүрдэх юм билээ. Жишээ нь жижиг, жижиг өрхийн эмнэлэг байгуулчхаад байдаг, тэнд ахисан шатын гэдэг юм уу эмчилгээ үзүүлж чадахгүй байгаа байхгүй юу хүн ам нь байхгүй учраас. Зүгээр ойр зуурын тариа тарьдаг ч юм уу, вакцин тариад гаргаад байгаа учраас бас иргэд маань бухимдаад хотын төв рүүгээ яваад байгаа юм.

Тэгэхээр бид хэд энэ зохист харьцаа буюу хүн ам байж бас тодорхой хэмжээний үйлчилгээний стандартуудыг төлөвлөхөөс өөр аргагүй. 10 мянгатай хүн дээр нэг спортын ордон ч гэдэг юм уу төлөвлөхгүй л бол 2, 3-хан мянган хүн дээр яах юм бол нөгөө юм нь амьдардаггүй ч юм уу ингээд бас энэ нөхцөл байдлыг бид хэд бас харгалзаж бол үзсэн. Мэдээж орон нутгийн юман дээр яах вэ бас өөр бас зүйлүүд онцлогууд байхыг бас үгүйсгэхгүй. Тэгэхээр ер нь энэ зүгээр хотынхоо нийтлэг байдлаар авч үзсэн.

Н.Энхболд: Учрал гишүүн ажлын хэсгийн ахлагч.

Н.Учрал: Тийм энэ Шадар сайдын бас санал бас үндэслэлтэй байгаа юм. Жишээ нь анх яг энэ ажлын хэсэг дээр яг энэ асуудлаар ярихад улсын зэрэглэлтэй хот, орон нутгийн зэрэглэлтэй хот гээд

ингээд 2 статус байгаа. Гэтэл одоо жишээ нь Улаанбаатар нийслэлд харьяалагдаж байгаа Налайх, Багануур 2 болбол улсын зэрэглэлтэй хот болно. Тэгэхээр нөгөө иргэдээсээ захирагчаа сонгоход түүнийг нь нийслэлд шууд харьяалуулж үзэх нь бас зохимжгүй ийм ойлголт бий болж байна л даа.

Яагаад гэхээр Дархан, Эрдэнэт 2 болбол бас улсын зэрэглэлтэй хот болчихно. Тэгэхээр улсын зэрэглэлтэй хот бол иргэд нь сонгогчоод, түүнийг нь Ерөнхий сайд батламжлаад байхад, яг адилхан улсын чанартай, зэрэглэлтэй хотын статустай Налайх, Багануурыг Нийслэлийн дарга нь дахиад захирамжилна гэхээр энэ болбол яг ийм ойлголтыг яг энэ саяын заалт төрүүлээд байгаа учраас зүгээр нэг Амарсайхан сайдын энэ зарчмын зөрүүтэй санал дээр болбол бид бас саналаа хэлээд, хураалгахад болохгүй зүйл байхгүй юм байна л гэж ойлгож байгаа. Жишээ нь, тийм тоог нь.

Дээрээс нь тоог нь өөрчлөх асуудал дээр яах вэ энэ тоог ч гэсэн мэдээж Их Хурлын гишүүн бас саналаа гаргаад энэ дээр болбол бас саналаа оруулчхаж болбол болно. Бид болбол хуулийн төсөл дээр орж ирсэн байдлаар нь л авч үзсэн. Засгаас өргөн барьсан хуулийн анхны төслөөр л ингээд явж байгаа, энийг болбол хөндөөгүй. Мэдээж ажлын хэсгийнхэн болбол тэнд чинь мэдээж зах зээл, амьдрал ахуй үргэлжлэх ёстой учраас 8 мянга орчим хүнтэй байж нэг орон нутгийн зэрэглэлтэй хотын нэг хороо үүсэхгүй болбол 2 мянган хүнтэй хороо дахиад хэд хэдийг байгуулаад байх нь зохимжгүй юм.

Яагаад гэхээр энэ хуулиар бид нар сая ажлын хэсгээс ч гэсэн тэр алслагдсан хотуудад хэрвээ үйлчилгээ явагдвал явагдах юм болбол бас татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, нөгөө хувийн хэвшил тэнд тэр нийтийн номын сан, тэр үзвэр үйлчилгээ, хүнсний зах, худалдааны төв, бусад үйлчилгээ явуулахад татварын болон татварын

бус дэмжлэг үзүүлэх гээд байгаа учраас тэнд мэдээж бизнесийн үйл ажиллагаа явахад тодорхой төвлөрөл хэрэгтэй гэдэг утгаар нь ЗГ-аас хуулийг өргөн мэдүүлэхдээ нэг ийм тоо тавьсан.

Гэхдээ улсын зэрэглэлтэй хотод бид нар Налайх, Багануурыг хамааруулж энэ хуулиар оруулж ирж байгаагийн хувьд болбол тэр 2 хотын хувьд энэ 10 мянга, 8 мянга гэдэг бол бас харьцангуй өндөр тоо байх ийм бас эргэлзээ үүсэж байгаа учраас түүнийг болбол бас эргээд харж болбол болох юм. Тэгэхээр Их Хурлын гишүүний хувиар бас та саналаа гаргаад явчхаж болох байх гэж бодож байна.

Н.Энхболд: Энэ гишүүд хаачив? Сарангэрэл гишүүн, хэн 2 хаачив, Мөнх-Оргил гишүүн хаачив? Гэхдээ байж байхгүй бол энэ чинь гаднын олон хүмүүс

байж байна байгууллагын хүмүүс, хөдөө орон нутгаас ирчихсэн тосгоны захирагч нар сууж байна. Тэгэхэд бид нар ингээд л орж, гараад л, тэр дэмжсэн гэж үзээрэй гээд ингээд байж болохгүй байна л даа. 1, 2, 3, 4, 5. Адьшаа манайх биш л дээ. Мөнх-Оргил, Ганболд хоёрыг дууд. Ирэхгүй болбол энэ хурлыг хойшлуулъя. Ингээж хариуцлагагүй хуралдаж болохгүй шүү.

18.12 цаг

Маргааш Байнгын хороог хойшлуулж, хойшлууллаа. Цагтаа ирж, хуралдаа хариуцлагатай орцгооно шүү.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

